МОНГОЛБАНК

ИНФЛЯЦИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЙЛАН

2017

3-Р САР

“Инфляцийн төлөв байдлын тайлан”-г Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн инфляцийг онилсон мөнгөний бодлогын уян хатан арга хэлбэрийн хүрээнд олон нийтэд бэлтгэн хүргэж байна. Уг тайланг улирал бүр боловсруулж гурав, зургаа, ес, арван хоёрдугаар саруудад Монголбанкны цахим хуудаст байршуулна.

ХОЛБОО БАРИХ:

Монголбанк, Олон нийтийн боловсрол мэдээллийн төв
Утас: 976-11-310081
Факс: 976-11-311471
Цахим шуудан: communication@mongolbank.mn
Цахим хуудас: www.mongolbank.mn

ГАРЧИГ

ТОЙМ **3**

I. ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ **5**

I.1 Төсөөлөлд ашигласан гадаад таамаглал **5**

I.2 Төсөөлөл, түүний тодорхой бус байдал **8**

II. ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ **11**

II.1 Инфляци **11**

II.1.1 Инфляцийн зорилт, хэрэгжилт 11

II.1.2 Инфляци, түүний бүрэлдэхүүн 12

II.2 Эрэлт, нийлүүлэлт **14**

II.2.1 Нийт эрэлт 14

II.2.2 Нийлүүлэлт 17

II.2.3 Потенциал үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн зөрүү 19

II.3 Монгол улсын нэгдсэн төсөв, засгийн газрын өр **20**

II.4 Хөдөлмөрийн зах зээл **23**

II.4.1 Ажил эрхлэлт ба ажилгүйдэл 23

II.4.2 Цалин, бүтээмж 24

II.5 Мөнгө, санхүүгийн зах зээл **25**

II.5.1 Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд 25

II.5.2 Хүү 28

II.5.3 Валютын ханш 29

II.5.4 Үл хөдлөх хөрөнгийн зах зээл 31

II.6 Төлбөрийн тэнцэл **33**

II.6.1 Урсгал данс 33

II.6.2 Хөрөнгө, санхүүгийн данс 34

II.7 Гадаад эдийн засгийн орчин **35**

II.7.1 Худалдааны гол түнш орнуудын эдийн засгийн байдал 35

II.7.2 Монгол улсын экспортын гол нэрийн барааны дэлхийн зах зээл дээрх үнэ 38

ТОЙМ

Монгол улсын гадаад эрэлт 2016 оны IV улиралд хүлээж байснаас бага зэрэг сайжирсан хэдий ч цаашид тогтвортой үргэлжлэх эсэх нь эргэлзээтэй байна. Манай улсын худалдааны гол түнш БНХАУ болон Евро бүсийн эдийн засаг тайлант улиралд хүлээж байснаас өндөр өсөлттэй гарсан ч 2017, 2018 онуудад буурах эрсдэлтэй байна. Харин ОХУ-ын эдийн засгийн өсөлт эрчимжих төлөвтэй байна.

Төсвийн зөөлөн бодлогоор хэрэглээг урамшуулж, хөрөнгө оруулалтыг тэтгэснээр Хятадын эдийн засаг 2016 онд хүлээж байснаас өндөр өсөлттэй гарсан хэдий ч хувийн хэвшлийн өр өссөн, зарим салбарт илүүдэл хүчин чадал үүссэн зэрэг нь эдийн засгийн өсөлтийг цаашид сааруулах эрсдлийн хүчин зүйл болж байна. Газрын тосны хямд үнэ, уламжлалт бус мөнгөний тэлэх бодлого хэрэгжүүлж Евро бүсийн дотоод эрэлтийг дэмжсэнээр хөдөлмөрийн зах сэргэж, эдийн засгийн өсөлт нэмэгдсэн. Евро бүсийн томоохон улсуудад болох сонгууль, Их Британи Европын холбооноос гарах зэрэг асуудлууд нь уг бүсийн эдийн засгийн төлөвт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна. Уул уурхай, хөдөө аж ахуйн салбар идэвхжиж, ОХУ-ын эдийн засгийн өсөлт нэмэгдэх төлөвтэй байна.

2011 оны сүүлчээс эхлэн тасралтгүй муудаж байсан гадаад худалдааны нөхцөл тайлант улиралд эрс сайжирлаа. Үүнд экспортын үнэ, тэр дундаа нүүрс, зэсийн үнэ хүлээж байснаас илүү ихээр өссөн нь нөлөөлөв. Төсвийн тэлэх бодлогын нөлөөгөөр Хятадын барилгын материалын эрэлт нэмэгдсэн нь нүүрс, зэсийн үнэ 2016 оны 4 дүгээр улиралд огцом өсөхөд нөлөөлсөн боловч энэ өсөлт удаан хадгалагдахгүй гэж шинжээчид үзэж байна. Иймээс 2017 оны 2 дугаар улирлаас эхлэн манай экспортын үнэ буурч, улмаар худалдааны нөхцөл эргэн муудаж болзошгүй байна. Холбооны Нөөцийн Банк 2016 оны 12 болон 2017 оны 3 дугаар саруудад бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн нь алтны үнийн цаашдын төлөвт сөргөөр нөлөөлнө гэж шинжээчид үзэж байна. Газрын тосны гол нийлүүлэгч орнууд үйлдвэрлэлээ бууруулах нэгдсэн ойлголтод хүрснээр үйлдвэрлэл цаашдаа бодитой буурч, үнэ өсөх хүлээлт бий болж байна. Гэхдээ АНУ-ын газрын тосны олборлолт тасралтгүй нэмэгдэж байгаа нь газрын тосны үнийн өсөлтийг сааруулахаар байна.

Тайлант улиралд урсгал тэнцлийн алдагдал буурч, хөрөнгө санхүүгийн тэнцэл сайжирснаар төлбөрийн тэнцлийн алдагдал буурлаа. Экспортын үнийн өсөлт урсгал тэнцлийн алдагдлыг бууруулсан бол гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь хөрөнгө санхүүгийн тэнцлийн ашгийг нэмэгдүүлсэн.

Экспортын зарим бүтээгдэхүүний үнийн сэргэлт тайлант улиралд эдийн засгийн өсөлтийг тэтгэж, хүлээлтээс өндөр гарахад голлон нөлөөлөв. Үнийн өсөлтөөс үүдэн нүүрс, төмрийн хүдрийн олборлолт нэмэгдэж, тээврийн салбарын өсөлт тайлант улиралд эрчимжсэн байна. Газар тариалангийн салбарт арвин ургац авсан нь ХАА-н салбарын өсөлтийг тэтгэсэн бол машин механизм, тоног төхөөрөмжийн борлуулалт өссөн нь худалдааны салбарын өсөлтийг нэмэгдүүлэв. Сүүлийн 6 улирал дараалан агшаад байсан уул уурхайн бус салбарууд тайлант улиралд нийлбэр дүнгээрээ огцом өсч, улмаар нийт үйлдвэрлэл эрчимжлээ.

Тайлант улиралд уул уурхайн бус зарим салбаруудын үйлдвэрлэл огцом нэмэгдсэн боловч хөдөлмөрийн захын төлөв төдийлөн сайжраагүй. Ажил эрхлэлт буурч, ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, өрхийн цалингийн орлого буурсан хэвээр байна.

Эдийн засгийн өсөлтийг эрэлт талаас харвал 2016 оны 4 дүгээр улиралд цэвэр экспорт, Оюу толгойн далд уурхайн хөрөнгө оруулалтыг даган хөрөнгө оруулалт өсч, өрхийн хэрэглээ нэмэгдсэн нь нийт эрэлтэд эерэг нөлөө үзүүлсэн бол Засгийн газрын хэрэглээ сөрөг нөлөө үзүүлэв. Харин 2016 оныг бүхэлд нь авч үзвэл өмнөх онтой харьцуулахад хувийн хэрэглээ буурч, засгийн газрын хэрэглээ, хөрөнгө оруулалт, цэвэр экспорт өссөн байна.

Төсвийн зарлага орлогоосоо их хэмжээгээр тэлсэн нь төсвийн алдагдал, Засгийн газрын өрийг нэмэгдүүлэн төсвийн тэлэх бодлогын далайц буюу төсвийн импульс 2016 онд огцом нэмэгдэхэд

нөлөөллөө. Төсвийн орлого 2016 онд өмнөх оноос 2 хувиар буурсан байхад төсвийн зарлага өмнөх оноос 30 гаруй хувиар тэлж, Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2016 онд 27 нэгж хувиар нэмэгдсэн.

2014 оны дунд үеэс эхэлсэн жилийн инфляцийн буурах хандлага өөрчлөгдөж, 2016 оны 12 дугаар сард өслөө. Нийлүүлэлтийн шалтгаантай инфляци, тэр дундаа махны үнэ жил гаруй хугацаанд инфляцийг бууруулах нөлөөтэй байсан ч оны сүүлчээр инфляцийг нэмэгдүүлэх нөлөө үзүүллээ. Мөн хүнсний бус инфляцийн хувьд ч энэхүү хандлага ажиглагдлаа.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт болон зээлийн өсөлт тайлант улиралд жилийн өмнөх түвшнээс өслөө. Тайлант улиралд Засгийн газар дотоод бонд шинээр гаргаж төсвийн алдагдлыг санхүүжүүлсэн нь мөнгөний нийлүүлэлт өсөхөд нөлөөллөө. Эдийн засгийн идэвх ихэнх салбаруудад сэргээгүй, чанаргүй зээл нэмэгдсэн, төсвийн алдагдал өндөр хэвээр байгаа нь шинээр олгох зээл хумигдахад нөлөөлж байна. Шинээр олгосон зээлийн бүтцийг авч үзвэл хэрэглээний зээл дийлэнх хэсгийг бүрдүүлсээр байна. Өрхийн нэрлэсэн болон бодит орлого буурсаар байгаа нь хэрэглээний зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх шалтгаан болж байна.

Хөрөнгийн захын үзүүлэлтүүд 2016 онд хэлбэлзэл өндөртэй байлаа. ТОП-20 индекс 2016 онд ерөнхийдөө буурах хандлагатай байсан ч 11, 12 дугаар сард өссөн. Харин 2015 оны эхнээс үргэлжилж буй орон сууцны үнийн буурах хандлага үргэлжилсээр байна.

Эдийн засгийн өсөлт 2017 онд эерэг болж, 2018 онд тогтворжих хүлээлттэй байна. Уул уурхайн хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлтийг, тэр дундаа боловсруулах, барилга, худалдаа зэрэг уул уурхайн бус салбаруудын өсөлтийг тэтгэхээр байна. Нөгөөтэйгүүр, төсвийн хумих бодлого хэрэгжсэнээр эдийн засгийн идэвхжлийг богино хугацаандаа сааруулах хэдий ч дунд хугацаандаа эдийн засгийн ерөнхий төлөв эргэн сэргэхэд эерэгээр нөлөөлөхөөр байна. Цаашид нийт эрэлт нэмэгдэх, ханшийн сулралтын дамжих нөлөө болон татварын өсөлтөөс шалтгаалж импортын барааны үнэ, улмаар үнийн ерөнхий түвшин өсөх боловч инфляци зорилтот түвшнээс давж гарахааргүй байна.

Гадаад орчны хувьд гадаад эрэлт, экспортын гол барааны үнэ БНХАУ-ын эдийн засгийн бодлогын тодорхой бус байдлаас шалтгаалан хэлбэлзэж болзошгүй байна. Эдийн засгийн дотоод орчны хувьд төсөв болон хөрөнгийн орох урсгал хэр ихээр өөрчлөгдөх, эдийн засгийн томоохон төслүүд хэзээ, хэрхэн хэрэгжих зэрэг нь дотоод тодорхой бус байдлын эх сурвалж болж байна.

I. ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

I.1 Гадаад эдийн засгийн талаар төсөөлөлд ашигласан таамаглал[1]

Өмнөх төсөөлөлтэй харьцуулахад 2017 онд Евро бүсийн өсөлт хэвээр хадгалагдаж, БНХАУ-ын өсөлт нэмэгдэж, ОХУ-ын эдийн засгийн өсөлт буурлаа. Өмнөх төсөөллөөс зэс, нүүрсний үнэ өсч, алтны үнэ буурснаас худалдааны нөхцөл 2017 сайжирсан байна.

Гадаад эрэлт

Монгол улсын гадаад эрэлтийн таамаглалыг өмнөх төсөөллөөс сайжрууллаа. Төсөөлөл хийж буй хугацаанд Хятадын эдийн засгийн өсөлт өмнөх төсөөлөлтэй харьцуулахад бага зэрэг сайжирч, ОХУ болон Евро бүсийн өсөлтийг хэвээр авч үзлээ .
Хэдийгээр Хятадын эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс нэмэгдсэн ч хувийн секторын өрийн хэмжээ хурдацтай нэмэгдэж, экспортын төлөв байдал таагүй байгаагаас шалтгаалан өсөлт нь 2017-2018 онд саарах хүлээлттэй байна. Харин ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2017 онд нэмэгдэж, 2018 онд тогтвортой хадгалагдах бол Евро бүсийн өсөлт 2017-2018 онд бага зэрэг саарах төсөөлөлтэй байна.

Зураг I.1.1

Гадаад эрэлтийн өөрчлөлт, хувиар

Эх сурвалж: Блүмберг, Рубини, ОУВС

БНХАУ-ын Засгийн газар төсвийн зөөлөн бодлого хэрэгжүүлж, төсвийн зардал, дэд бүтцийн хөрөнгө оруулалт зэргийг нэмэгдүүлж эхэлснээс хэрэглээ өсч, хөрөнгө оруулалтын өсөлт тогтвортой байсан нь эдийн засгийн өсөлт 2016 онд хүлээлтээс өндөр гарахад нөлөөллөө. Гэвч хувийн секторын өр болон экспортын үнийн төлөв байдалтай холбоотойгоор өсөлт 2017 онд 6.4 хувь, 2018 онд 6 хувь болж доошлохоор байна. Харин Евро бүсийн эдийн засаг 2016 онд өмнөх төсөөллөөс нэмэгдэв. 2016 оны IV улиралд Евро бүсийн дотоод эрэлт газрын тосны хямд үнэ, мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогын нөлөөгөөр өсч, хөдөлмөрийн зах сэргэж эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Нийт Евро бүсийн ДНБ-ний тал хувийг тодорхойлогч Нидерланд, Франц, Герман зэрэг улсуудад 2017 онд болох сонгууль эдийн засгийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлэхээр байна. Түүнчлэн Их Британи Европын холбооноос гарах асуудал, террорист халдлага, улс төрийн үйл явдлууд эдийн засгийн өсөлтийг сааруулах магадлалтай байгаагаас 2017 оны Евро бүсийн эдийн засгийн өсөлтийг өмнөх төсөөллөөс өөрчлөлгүй үлдээж, 2018 оны төсөөллийг 0.1 хувиар бууруулж 1.5 хувьд хүргээд байна. ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2017 оны эхний улирлаас эерэг болж алгуур өсөх төлөвтэй байна. Хэдийгээр барилгын салбарын уналт, үйлдвэрлэл, бөөний болон жижиглэнгийн худалдаа, санхүүгийн үйл ажиллагаа буурсан ч уул уурхайн салбар сэргэж, хөдөө аж ахуйн салбар эрчимжиж эхэлсэн.Иймд ОХУ-ын эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 2017-2018 оны эцэст тус бүр 1.4 хувь байхаар авлаа.

[1]Худалдааны түнш орнуудын өсөлт, инфляцийн төсөөллийг Roubini Global Economics-ийн 2017 оны 2 дугаар сарын тайлан, EIU-ийн 2 дугаар сарын тайлан, Bloomberg-ийн судлаачдын төсөөллүүдийн медиан утга, IMF-WEO-ийн 12 дугаар сарын төсөөллүүдээс авч, зохих тайлбарыг эдгээр тайлангуудаас нэгтгэн оруулсан. Үүнд Монголбанкны судлаачийн үнэлэлт, дүгнэлт ороогүй болно.

Гадаад хүү

АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн дараагаар Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүгээ 12 дугаар сард 0.25 нэгж хувиар нэмэгдүүлсэн. Түүнчлэн АНУ-ын ажилгүйдлийн түвшин буурч, инфляци өсч, иргэдийн бодит орлого нэмэгдэж, дэлхийн санхүүгийн зах зээл тогтворжиж эхэлснээс Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ 2017 оны 3-р сард дахин 0.25 нэгж хувиар нэмэгдүүлэв. Холбооны нөөцийн банк цаашид ч бодлогын хүүгээ дахин нэмэгдүүлэх хүлээлт хэвээр байна.

Зураг I.1.2

Холбооны нөөцийн банкны хүү, хувиар

Эх сурвалж: Блүмберг

Худалдааны нөхцөл

Зэс, нүүрсний үнэ өсч, 2016 онд худалдааны нөхцөл сайжирсан бол 2017 онд зэс, нүүрс, төмрийн хүдрийн үнэ өмнөх улирлын түвшнээс буурч, газрын тосны үнэ нэмэгдэн худалдааны нөхцөл эргээд муудаж болзошгүй байна. Харин 2018 онд алт, зэсийн үнэ сэргэж худалдааны нөхцөл сайжрах төсөөлөлтэй байна.

Зураг I.1.3

Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт

Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

Хятадын барилгын материалын эрэлт нэмэгдсэн нь нүүрс, төмрийн хүдэр, зэсийн импортыг нэмэгдүүлж, эдгээрийн үнэ 2016 оны IV улиралд огцом өслөө. Трампын ялалтаас хойш зэсийн үнэ тогтвортой өсч 6000 ам.долларын түвшинд хүрээд байсан ч энэ өсөлт тийм ч удаан үргэлжлэхгүй, энэ ондоо эргээд буурч болзошгүй гэж шинжээчид үзэж байна. Гэсэн хэдий ч зэсийн үнэ өмнөх төсөөллөөс 2017 онд 302 ам.долларaар нэмэгдэх бол 2018 онд 102 ам.долларaар буурах төсөөлөлтэй байна. 2016 оны сүүлийн хагаст хүрэн нүүрсний нийлүүлэлт багасахын зэрэгцээ эрэлт нь нэмэгдэж, үнэ өссөн. Өвлийн өндөр эрэлттэй уялдуулан БНХАУ-ын Засгийн газраас нүүрсний үйлдвэрлэлийг хязгаарлах бодлогоо зөөллөснөөс 11 дүгээр сарын түвшинтэй харьцуулахад үнэ 14 хувиар бууraад байна. Харин 3 дугаар сард энэхүү бодлогоо эргээд чангалах хүлээлттэй байгаа ч одоогоор албан ёсны шийдвэр гараагүй байна. Хэрэв энэхүү бодлого албан ёсоор хэрэгжиж эхэлвэл нүүрсний үнэд эерэг хандлага гарах ч 2017 онд сүүлийн хагаст 2016 оны эцсийн түвшин рүү буурахаар төсөөлөлд ашиглалаа.

2016 оны IV улирлаас дэлхийн үнэт цаасны зах зээл сэргэж, Холбооны Нөөцийн Банк 12 дугаар сард бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар нэмэгдүүлснээр ам.долларын ханш чангарсны улмаас бууraад байсан алтны үнэ 2017 оны 2 дугаар сард эргэн өссөн байна. Ам.долларын ханш суларч, хөрөнгө оруулагчид алтны зах зээл рүү эргээд хөрөнгийн урсгалаа чиглүүлсэн зэрэг нь алтны ханшид дэмжлэг болсон. Гэвч АНУ-ын эдийн засгийн ерөнхий нөхцөл байдлын талаарх эерэг хүлээлтүүд зах зээл дээр нэмэгдэхийн хэрээр алтны эрэлт буурч, бусад хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн өгөөж нэмэгдэх хандлага бий болж байна. Иймд алтны үнийн төсөөллийг өмнөх

төсөөллөөс бууруулж авлаа. ОПЕК үйлдвэрлэлээ танах шийдвэрийн дараа нийлүүлэлтийн илүүдэлд ороод байсан газрын тосны зах зээлд үнэ эргээд сэргэх хандлага ажиглагдаж эхэлснээр 2016 оны сүүлээс үнэ өсч эхэлсэн. 2017 он гарсаар ОПЕК болон ОПЕК-ийн бус орнуудын гол нийлүүлэгчид үйлдвэрлэлээ бууруулах шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих арга замаа тодорхойлж, нэгдсэн ойлголтод хүрснээр үйлдвэрлэл цаашид бодитой буурах хүлээлт бий болж, үнэ өсөх хүлээлт нэмэгдэж байна. Гэвч АНУ-ын агуулахуудад газрын тосны нөөцийн үзүүлэлт тасралтгүй нэмэгдэж байгаа нь газрын тосны үнийн өсөлтийг сааруулах нөлөө үзүүлэхээр байна.

Гадаад инфляцийн хувьд Оросын инфляци өмнөх төсөөллөөс буурахаар байгаа бол Хятад, Евро бүсийн инфляци нэмэгдэх төлөвтэй байна. Сүүлийн дөрөв гаруй жилийн хугацаанд дефляцитай байсны эцэст үйлдвэрлэлийн бууралт болон түүхий эдийн үнийн өсөлтийн эерэг нөлөөгөөр Хятадын инфляци ялимгүй өсчээ. Гэсэн хэдий ч Хятад, Евро бүсийн инфляци зорилтоос доогуур байхаар байна. Оросын эдийн засгийн идэвхжил сул, мөнгөний бодлого чанга хэвээр байгаа нь инфляци буурахад нөлөөлж, 2016 оны эцэст 5.8 хувь, 2017 онд 5 хувь, 2018 онд 4.4 хувь байх төсөөлөлтэй гарлаа.

I.2 Төсөөлөл, түүний тодорхой бус байдал

Эдийн засгийн өсөлт

Төсөөлөлд бодлогын хүүг өөрчлөхгүй, ОУВС-гийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-т тусгагдсан мөнгөний болон төсвийн бодлогын арга хэмжээнүүд хэрэгжинэ, Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт төлөвлөгөөний дагуу хэрэгжинэ гэсэн таамаглалыг ашиглав.

Эдийн засгийн өсөлт[2]-ийн төлөв өмнөх төсөөллөөс өсөхөд 2016 оны сүүлийн улиралд экспортын үнэ хүлээж байснаас илүү өсч, нүүрс, төмрийн хүдрийн олборлолт нэмэгдсэн нь нөлөөллөө. Уул уурхайн салбарт гарсан эерэг нөлөө тээвэр агуулах, худалдаа зэрэг уул уурхайн бус салбаруудад нөлөөлсөн нь төсөөллийн зөрүүтэй байдлыг голлон тайлбарлаж байна.

Суурь төсөөллөөр эдийн засгийн өсөлт 2017, 2018 онд бага зэрэг нэмэгдэх төлөвтэй байна. Уул уурхайн хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлтийг, тэр дундаа боловсруулах, барилга, худалдаа зэрэг уул уурхайн бус салбаруудын өсөлтийг тэтгэхээр байна. Нөгөөтэйгүүр, төсвийн хумих бодлого хэрэгжүүлснээр эдийн засгийн идэвхжлийг богино хугацаандаа сулруулах нөлөө үзүүлэх боловч эдийн засгийн ерөнхий төлөвт дунд хугацаандаа эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Уул уурхайн бус ДНБ-ний өсөлт 2017-2018 онуудад эрчимжих тооцоо гарсан. Оюу толгойн далд уурхайн хөрөнгө оруулалт 2017 онд нэмэгдэх, ОУВС-гийн хөтөлбөр хэрэгжсэнээр төсвийн алдагдлыг гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх, эдийн засгийн хүлээлт сайжрах зэрэг нь уул уурхайн бус салбарт эерэг нөлөө үзүүлэхээр байна. 2018 онд Оюу толгойн хөрөнгө оруулалт, далд уурхайн бүтээн байгуулалтын нөлөөгөөр уул уурхайн бус салбарын өсөлт урт хугацааны дундаж түвшин рүү дөхөх хүлээлттэй байна.

Нүүрс, алтны үйлдвэрлэл нэмэгдэх боловч Оюу толгойн баяжмал дахь металлийн агууламж 2017 оны олборлолтын явцад буурахаар байгаа нь 2017 онд уул уурхайн салбарын агшилтыг бий болгохоор байна. 2018 оноос Оюу толгойн металлийн агууламж эргэн нэмэгдэж, алтны үйлдвэрлэл нэмэгдсэнээр уул уурхайн салбарын өсөлт сэргэхээр байна.

Зураг I.2.1

Улирлын ДНБ-ий жилийн өсөлтийн төсөөлөл

Эх сурвалж: Монголбанк

	2016 *гүйц.*	2017* *төсөөлөл*[3]	2018*
ДНБ-ий өсөлт	1.0	1.5 – 2.5	4.2 – 6.2
Инфляци, ХҮИ[4]	-0.3	5.8 – 7.2	5.4 – 7.4

Эх сурвалж: Монголбанк

[2] Улирлын ДНБ-ний жилийн өсөлт
[3] 30 хувийн итгэх интервал
[4] Он тус бүрийн 4 дүгээр улирлын дундаж инфляци

Инфляци

Инфляци 2017, 2018 онуудад өсөхөөр байгаа боловч зорилтоос бага байх төлөвтэй байна. Эдийн засгийн өсөлт IV улиралд хүлээлтээс сайжирсантай холбоотойгоор инфляцийн таамаглал өмнөх төсөөллөөс нэмэгдсэн.

Цаашид эдийн засгийн өсөлт эрчимжих болон төгрөгийн ханш өмнөх жилтэй харьцуулахад суларсан нь хүнсний бус инфляцийг 2017 онд өсгөхөөр байна.

Хэрэглээний сагсны хүнсний бүлгийн 30 орчим хувийг бүрдүүлдэг махны үнэ оны эхний хагаст өсөх, сүүлийн хагаст буурах улирлын онцлогоо даган өөрчлөгдөж, өмнөх жилтэй ойролцоо түвшинд байна гэж үзлээ. Харин дэлхийн зах зээл дээрх хүнсний үнийн өсөлт, төгрөгийн ханшийн сулралтын дам нөлөөгөөр махнаас бусад хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөхөөр байна. Үүнээс гадна автобензин, дизель түлшний онцгой албан татвар 2017 оны II болон IV улирлуудад нэмэгдэхээр байгаа нь үнийн ерөнхий түвшинг өсгөх нөлөө үзүүлэхээр байна.

Зураг I.2.2

Инфляцийн төсөөлөл

Эх сурвалж: Монголбанк

Төсөөллийн тодорхой бус байдал

Эдийн засгийн бодлого өөрчлөгдөх, бүтцийн шинжтэй өөрчлөлт бий болох, таамаглалд ашигласан нөхцлүүд өөрчлөгдөх болон урьдчилан харах боломжгүй гадаад, дотоод хүчин зүйлсийн гэнэтийн өөрчлөлт зэргээс шалтгаалж төсөөлөл бодит гүйцэтгэлээс зөрөх эсвэл дараагийн төсөөлөлд өөрчлөлт орох боломжтой. Макро эдийн засгийн бодлого, дотоод, гадаад хүчин зүйлст нөлөөлж болзошгүй дараах тодорхой бус байдлууд байна.

Эдийн засгийн гадаад орчны тодорхой бус байдал

- БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн ерөнхий төлөв сул хэвээр, 2018 онд 6 хувьд хүрч буурах төсөөлөлтэй байгаа нь манай улсын эдийн засгийн тодорхой бус байдлын гол эх сурвалж болсон хэвээр байна. Төсвийн зөөлөн бодлого хэрэгжүүлснээр Хятадын хэрэглээ өсч, орон сууцны зах зээл сэргэсэн ч энэ нь ердөө богино хугацаандаа эдийн засгийн өсөлтийг дэмжинэ гэж шинжээчид үзэж байна. Барилгын салбар сэргэж гангийн гол түүхий эд болох коксжих нүүрс, төмрийн хүдрийн эрэлт нэмэгдсэн ч энэ нь мөн л богино хугацааных гэдгийг шинжээчид анхааруулж байна.
- БНХАУ-ын хувийн секторын өр өсч, чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа нь компаниуд өрийн хямралд өртөх, банк, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдах, цаашлаад эдийн засгийн өсөлт саарах эрсдэлийг дагуулж байна.
- АНУ-ын ерөнхийлөгч Доналд Трампын цагаачлалыг хязгаарлах шийдвэр бодитойгоор хэрэгжиж эхэлсэн явдал нь дэлхийн улс орны удирдагч төдийгүй бизнесийнхнээс нэлээд их шүүмжлэл авч эхэлсэн. Энэхүү үйл явдал нь ам.долларын ханшид сөргөөр нөлөөлж, алтны эрэлтийг нэмэгдүүлж, 2017 оны эхний 2 сард үнэ өсөхөд нөлөөлсөн. Гэвч Холбооны Нөөцийн Банк 3 дугаар сард бодлогын хүүгээ дахин нэмэгдүүлсэн бөгөөд алтны үнэ цаашид хэрхэн өөрчлөгдөх нь тодорхой бус байна.
- АНУ-ын ерөнхийлөгч Трампын дэд бүтцийн хөрөнгө оруулалтын шийдвэр албажиж гарвал түүхий эдийн зах зээл дээр хүчтэй нөлөө үзүүлэхээр байна. Одоогоор Трампын дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр хэрхэн хэрэгжих нь тодорхой бус байгаа ч зэс тэргүүтэй металлуудын эрэлт болоод үнэнд нөлөөлж эхлээд байна.

Эдийн засгийн дотоод орчны тодорхой бус байдал

- ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд хэд хэдэн төрлийн татварыг нэмэгдүүлэхээр болсон бөгөөд автобензин, дизель түлшний онцгой албан татварыг 2017 оны 3 болон 4 дүгээр улирлуудад нэмэгдүүлэхэд инфляцид үзүүлэх шууд болон шууд бус нөлөөг тооцож төсөөлөлд тусгасан. Хэрэв татварын нөлөө тооцоолсноос өндөр байвал инфляци нэмэгдэх эрсдэлтэй.
- ОУВС-гийн хөтөлбөр хэрэгжих шийдвэр эцэслэн гарахтай холбоотойгоор зах зээлийн хүлээлт өөрчлөгдөж, ханш богино хугацаанд чангарах эрсдэл өндөр байна.
- Гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх эсэх, тухайлбал Таван толгойтой холбоотой хөрөнгө оруулалт болон эдийн засгийг сэргээх төлөвлөгөөний хүрээнд бодит секторыг дэмжихтэй холбоотой томоохон төслүүд хэзээ эхлэх, хэрхэн санхүүжих нь тодорхой бус байна.
- Бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн болзошгүй доголдол эсвэл илүүдэл инфляцийн төсөөллийг өөрчлөх эрсдэл болно. Тухайлбал нийлүүлэлтийн шалтгаантай инфляци бий болох, урьдчилан зарлаагүй эсвэл тооцоолоогүй төрийн зохицуулалттай бараа үйлчилгээний үнэ нэмэгдэх нь төсөөллийг өөрчлөх болно

II. ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

II.1 Инфляци

II.1.1 Инфляцийн зорилт, хэрэгжилт

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх жилийн инфляци 2016 оны эцэст улсын хэмжээнд 1.1 хувь болж өмнөх оноос 0.8 нэгж хувиар буурсан бол өмнөх улирлаас 1.2 нэгж хувиар нэмэгджээ. Харин Улаанбаатар хотын жилийн инфляци 2016 оны эцэст 0.5 хувь гарлаа. Энэ нь өмнөх оноос 0.6 нэгж хувиар бага, өнгөрсөн улирлаас 1.2 нэгж хувиар өндөр байна. Ийнхүү жилийн инфляцийн түвшин 2016 онд улсын болон Улаанбаатар хотын хэмжээнд нам түвшинд буюу зорилтот түвшинээс бага байв (Зураг II.1.1.1).

Жилийн инфляци 2016 оны 3 дугаар улирлын турш сөрөг түвшинд буюу дефляцитай байсан ч оны эцэст бага зэрэг өсч эерэг түвшинд хүрлээ. Энэ нь: 1) Хүйтний улирал эхэлж 2016 оны 11 дүгээр сард хатуу түлшний үнэ 17.4 хувиар нэмэгдсэн; 2) Сүүлийн 10 жилийн дунджаар 12 дугаар сард махны үнийн сарын өсөлт 3.2 хувь байсан бол 2016 оны 12 дугаар сард дунджаас давж 8.4 хувиар өссөн; 3) Өрхийн орлого буурах хандлага намжиж, төгрөгийн ханшийн сулрах хурд нэмэгдэж буй нь эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамтыг нэмэгдүүлж байгаа (Зураг II.1.1.2) зэрэгтэй холбоотой.

Инфляцийг хүнсний болон хүнсний бусаар ангилан авч үзвэл, хүнсний үнэ сүүлийн 16 сарын хугацаанд анх удаа жилийн инфляцид эерэг нөлөө үзүүлж эхэллээ. Махны үнэ тайлант улиралд, тодруулбал 12 дугаар сард улирлын онцлогоо даган нэмэгдсэн нь хүнсний үнэ өсөх гол шалтгаан байлаа. 2017 оны эхний хагаст махны үнэ улирлын онцлогоо даган үргэлжлэн өсөхөөр хүлээгдэж байна. Харин хүнснээс бусад бараа, бүтээгдэхүүний үнийн жилийн инфляцид эзлэх хувь хэмжээ сүүлийн 10 улиралд буурсаар тайлант улиралд 0 орчим боллоо. 2017 оны эхний хагаст тухайн бүлгийн үнэ өсөх улирлын онцлогын дарамт байхгүй хэдий ч төгрөгийн ханшийн суларсантай холбоотойгоор үнэ өсөх хандлага ажиглагдаж болзошгүй байна (Зураг II.1.1.3).

Зураг II.1.1.1

Жилийн инфляци улсын хэмжээнд 1.1 хувь, Улаанбаатар хотод 0.5 хувь байв..

Эх сурвалж: ҮСХ

Зураг II.1.1.2

Өрхийн орлого буурах хандлага намжиж, төгрөгийн ханшийн сулрах хурд нэмэгдэв…

Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

Зураг II.1.1.3

Хүнсний үнийн өөрчлөлт инфляцид эерэг нөлөө үзүүлж эхлэв…

Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

II.1.2 Инфляци, түүний бүрэлдэхүүн

Улаанбаатар хотын өргөн хэрэглээний үнэ 4 дүгээр улиралд нийтдээ 0.4 хувиар өсчээ. Үнэ оны 6-10 дугаар саруудын турш тасралтгүй буурч байсан бол 11, 12 дугаар саруудад дараалан өслөө. Үүний шалтгаан нь хатуу түлш болон махны үнэ улирлын онцлогтойгоор өссөнтэй холбоотой. Махнаас бусад хүнсний бүтээгдэхүүний үнэ оны эцэст олон жилийн чиг хандлагын дагуу бага зэрэг нэмэгдэв. Мөн төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ 12 дугаар сард бага зэрэг өссөн. Энэ нь төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээний хөлс тухайн сард 24.3 хувиар нэмэгдсэнтэй холбоотой. Харин бусад бараа, бүтээгдэхүүний үнийн (Зураг II.1.2.1-т улаанаар тэмдэглэсэн) хэлбэлзэл 2016 оны 11 дүгээр сарын хатуу түлшний үнийн огцом өсөлтийг хасч тооцвол харьцангуй тогтвортой байна (Зураг II.1.2.1).

Зураг II.1.2.1

Өргөн хэрэглээний үнэ 4 дүгээр улиралд 0.4 хувиар өсөв...[6]

Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

Үнийн өндөр хэлбэлзэлтэй[5] бараа, бүтээгдэхүүнийг хэрэглээний сагснаас хасч тооцдог суурь инфляци 2016 оны эцэст 0.5 хувь болж, өмнөх оноос 4.3 нэгж хувиар, өнгөрсөн улирлаас 0.3 нэгж хувиар буурчээ. Суурь инфляци сүүлийн 3 жилийн турш ерөнхий инфляциас өндөр байсан нь махны үнэ буурч байсантай холбоотой. Суурь инфляцийн тооцоонд ордоггүй мах, сүү, хүнсний ногооны дундаж үнийн жилийн өөрчлөлт сүүлийн 6 сарын хугацаанд сөрөг байсан бол 2016 оны 12 дугаар сард 0.4 хувийн өсөлттэй гарлаа. Энэ нь тухайн сард махны үнэ нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд уг нөлөөгөөр суурь болон ерөнхий инфляцийн зөрүү ариллаа (Зураг II.1.2.2).

Зураг II.1.2.2

Суурь болон ерөнхий инфляцийн зөрүү ариллаа[7]…

Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

[5]Өндөр хэлбэлзэлтэй 37 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг хэрэглээний сагснаас хасч тооцдог.
[6]Улаанбаатар хотын улирлын инфляцийг авч үзэв.
[7]Улаанбаатар хотын жилийн инфляцийг авч үзэв.

Улаанбаатар хотын инфляцийг бүтцээр нь задлан үзвэл 2016 оны 4 дүгээр улирлын дунджаар мах, махан бүтээгдэхүүн -0.05, махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн -0.22, төрийн зохицуулалттай үйлчилгээ 0.02, шатахуун -0.23, харин бусад бараа, бүтээгдэхүүн (зурагт улаанаар тэмдэглэгдсэн) 0.19 нэгж хувийн нөлөөг үзүүлжээ. Өмнөх улирлын дундажтай харьцуулвал, махны нөлөө 1.03 нэгж хувиар нэмэгдэж, махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн, төрийн зохицуулалттай үйлчилгээ, бусад бараа, бүтээгдэхүүний нөлөө харгалзан 0.06, 0.46, 0.39 нэгж хувиар буурав. Дийлэнх бүрэлдэхүүн хэсгүүдийн инфляцид эзлэх хувь хэмжээ ийнхүү буурч байгаа ч махны үнийн огцом өсөлт дангаараа ерөнхий инфляцийн чиглэлийг өөрчлөх нөлөөг үзүүлжээ (Зураг II.1.2.3).

Зураг II.1.2.3

4 сар үргэлжилсэн дефляци зогсов...[8]

Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

Махны үнэ 2016 оны эхний хагаст улирлын онцлогоо даган нийтдээ 52.1 хувиар (1 дүгээр улиралд 37.6%, 2 дугаар улиралд 10.6%) нэмэгдэж, 3, 4 дүгээр улирлуудад эргэн 23.5 болон 9.4 хувиар буурлаа. Тайлант улиралд 10 болон 11 дүгээр саруудад махны үнэ буурсан бол 12 дугаар сард 8.4 хувиар өссөн юм. Махны үнийн жилийн өсөлтийн дундаж утга 2016 онд -9.1 хувь байсан нь 2015 оны дунджаас 2.4 нэгж хувиар өндөр байна. 2015 оны 3 дугаар улирлаас эхлэн махны үнэ огцом хэлбэлзэж байсан бөгөөд энэ үеэс хойш үнийн хэлбэлзэл ерөнхийдөө улирлын хандлагатайгаа нийцтэй байсан хэдий ч далайц нь олон жилийн дунджаас өндөр байсар ирлээ. Энэхүү хандлага нь үнэ огцом буурсан ч богино хугацаанд эргэн өсөх, цаашлаад эргэн буурах орон зайг бий болгожээ (Зураг II.1.2.4).

Зураг II.1.2.4

Махны үнэ 2016 онд 5.4 хувиар өслөө...

Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

[8]Улаанбаатар хотын жилийн инфляцийг бүтцээр задлан үзэв.

II.2 Эрэлт, нийлүүлэлт

II.2.1 Нийт эрэлт

Нийт эрэлт 2016 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар, жилийн нийлбэр дүнгээр өмнөх оноос 1.1 хувиар тус тус өслөө. Тайлант улиралд өрхийн хэрэглээ, хөрөнгө оруулалт болон цэвэр экспорт улирлын ДНБ-ий өсөлтөд эерэг нөлөө үзүүлсэн бол засгийн газрын хэрэглээ өсөлтөд сөргөөр нөлөөллөө. Харин жилийн дүнгээр авч үзвэл өсөлтөд томоохон эерэг нөлөө үзүүлсээр ирсэн хувийн хэрэглээ энэ онд 8.8 хувиар буурч, ДНБ-ий өсөлтөд 5.1 хувийн бууруулах нөлөө үзүүлсэн бол бусад бүрэлдэхүүн хэсгүүд эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлсөн байна.

Хэрэглээ

Өрх: Тайлант улиралд өрхийн хэрэглээ жилийн өмнөх үеэс 1.0 хувиар тэлж, улирлын ДНБ-ний өсөлтийг 0.5 нэгж хувиар нэмэгдүүллээ. Өмнөх 2 улиралд дараалан агшаад байсан өрхийн хэрэглээ энэ улиралд өсөлттэй гарсан нь өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээний өсөлт, орон сууц, түлш, цахилгааны хэрэглээний өсөлттэй холбоотой байна.

Хувийн аж ахуйн орлого (мал аж ахуй, газар тариалан г.м.) буурсантай холбоотойгоор өрхийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 1.9 хувиар буурлаа. 2016 оны эхний 3 улирал дараалж буураад байсан тэтгэвэр, тэтгэмжийн орлого 4-р улиралд 1.6 хувиар өслөө. Өрхийн сарын бодит орлого сүүлийн 8 улирал дараалан буурч байгаа ч буурах хурд саарч байна. (Зураг II.2.1.2)

Тайлант улиралд өрхийн орлого буурсан боловч өрхийн хэрэглээ өссөн байна. Өрхийн бодит зарлага жилийн өмнөх түвшнээс 3.1 хувиар нэмэгдлээ. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад хүнсний бус зарлага 8.5 хувиар өссөн бол бусад төрлийн зарлага буурсаар байна. (Зураг II.2.1.3)

Зураг II.2.1.1

Эдийн засаг 2016 онд 1.1 хувиар өслөө.

Эх сурвалж: ҮСХ

Зураг II.2.1.2

Өрхийн бодит орлого сүүлийн 8 улирал дараалан хумигдлаа.

Эх сурвалж: ҮСХ

Зураг II.2.1.3

Тайлант улиралд өрхийн бодит зарлага өслөө

Эх сурвалж: ҮСХ

Засгийн газар: Тайлант улиралд засгийн газрын хэрэглээ өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар багасч, улирлын ДНБ-ий өсөлтөд 0.3 нэгж хувийн бууруулах нөлөө үзүүллээ. Жилийн нийлбэр дүнгээр 2016 онд засгийн газрын хэрэглээ өмнөх оноос 8.9 хувиар өсч, эдийн засгийн өсөлтөд 1.2 нэгж хувийн нэмэгдүүлэх нөлөөг бий болгосон байна. Эдийн засгийн идэвхжил сул байсан ч засгийн газрын зардал ийнхүү өссөн нь сонгуультай холбоотойгоор оны эхний хагаст төсөвт тусгагдаагүй зардлууд гарсантай холбоотой юм. (Зураг II.2.1.4)

Хөрөнгө оруулалт

Нийт хөрөнгө оруулалт (хөрөнгийн хуримтлал)-ын хэмжээ тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар тэлж, улирлын ДНБ-ий өсөлтөд 4.8 нэгж хувийн өсгөх нөлөө үзүүллээ. 2016 оны 4-р улиралд үндсэн хөрөнгийн хуримтлал өнгөрсөн оны мөн үеэс 36.6 хувиар нэмэгдсэн нь хөрөнгө оруулалт 16.3 хувиар тэлэх гол шалтгаан боллоо. Үндсэн хөрөнгийн хуримтлал ийнхүү өссөн нь Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалттай холбоотой зам, бусад барилга байгууламж өссөнөөр тайлбарлагдаж байна. (Зураг II.2.1.5).

Цэвэр экспорт

Цэвэр экспорт 2016 оны 4-р улиралд өнгөрсөн оны мөн үеэс 68.8 хувиар өсч, эдийн засгийн өсөлтийг 4.8 нэгж хувиар нэмэгдүүлэх нөлөө үзүүллээ. Импорт өнгөрсөн оны мөн үеэс 29.0 хувиар өссөн хэдий ч экспорт 33.4 хувиар өссөнөөр цэвэр экспорт өнгөрсөн оны мөн үеэс өссөн байна. (Зураг II.2.1.6).

Тайлант улиралд экспорт биет хэмжээгээр өмнөх оны мөн үеэс өсөхөд чулуун нүүрсний экспорт 140.2 хувь, мөнгөжөөгүй алтны экспорт 147.7 хувь, цайрын хүдэр 369.5 хувь өссөн нь голлон нөлөөллөө.

Зураг II.2.1.4

Засгийн газрын хэрэглээ

Эх сурвалж: ҮСХ

Зураг II.2.1.5

Хөрөнгийн хуримтлал 2016 онд эдийн засгийн өсөлтийг тэтгэлээ

Эх сурвалж: ҮСХ

Зураг II.2.1.6

Экспорт, импорт, *2010 оны зэрэгцүүлэх үнээр*

Эх сурвалж: ҮСХ

Оюу толгойн импорттой холбоотойгоор 2017 онд импортын хэмжээ өсөх бол Оюу толгойн баяжмалын металын агууламж буурч экспорт үнийн дүнгээрээ буурах төлөвтэй байна.

Тайлант улиралд машин тоног төхөөрөмж, үйлчилгээний импортын өсөлтөөс шалтгаалж бараа, үйлчилгээний нийт импорт нэрлэсэн дүнгээр өнгөрсөн оны мөн үеэс 3.6 хувиар өслөө. Алт болон чулуун нүүрсний экспорт өссөнөөр бараа, үйлчилгээний экспорт 2016 оны 4-р улиралд нэрлэсэн дүнгээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 42.2 хувиар өсч, гадаад худалдаа 330 сая ам.долларын ашигтай гарлаа. (Зураг II.2.1.7)

Зураг II.2.1.7

Цэвэр экспорт ашигтай гарлаа, *оны үнээр*

Эх сурвалж: Монголбанк

Дотоод эрэлтийг 2014 оны 2-р улирлаас хойш 9 улирал дараалан бууруулах нөлөө үзүүлсэн хөрөнгө оруулалт (нийт хуримтлал) сүүлийн 2 улиралд дотоод эрэлтийг нэмэгдүүллээ. Гэвч дотоод эрэлтийг тэтгэсээр ирсэн өрхийн хэрэглээ сүүлийн 2 улирал дараалан дотоод эрэлтэд бууруулах нөлөө үзүүллээ. Ингэснээр дотоод эрэлт сүүлийн 9 улирал дараалан агшиж байна.[9] (Зураг II.2.1.8)

Зураг II.2.1.8

Дотоод эрэлт сүүлийн 9 улирал дараалан агшиж байна.

Эх сурвалж: ҮСХ

[9] Зураг II.2.1.8-д өрхийн хэрэглээ, засгийн газрын хэрэглээ, нийт хуримтлалыг тооцохдоо тухайн улирлын утга дээр өмнөх гурван улирлын утгыг нэмж тооцсон.

II.2.2. Нийт нийлүүлэлт

Бодит ДНБ-ий өсөлт 2016 оны эхний гурван улиралд 1.6 хувийн уналттай, 4-р улиралд 7.8 хувь өсч эрчимжсэнээр оны дүнгээр эдийн засаг 1.0 хувиар өслөө. Сүүлийн зургаан улирлын турш агшиж байсан уул уурхайн бус салбарууд 4-р улиралд 10.3 хувиар огцом өссөн бол уул уурхайн салбар 1.9 хувиар өслөө.

Тайлант улиралд эдийн засгийн өсөлтийн дийлэнх буюу 2.7 нэгж хувийг тээвэр агуулах, 1.2 нэгж хувийг хөдөө аж ахуй, 1.0 нэгж хувийг худалдаа, 1.0 нэгж хувийг бүтээгдэхүүний цэвэр татварын өсөлт тус тус тайлбарлаж байна. Мөн бусад үйлчилгээ[10], боловсруулах, уул уурхайн салбарууд тус бүр 0.6-0.8 нэгж хувийн эерэг нөлөөг өсөлтөд үзүүлэв. Мэдээлэл холбоо, эрчим хүчний салбарууд тайлант улирлын эдийн засгийн идэвхжилд төдийлөн нөлөө үзүүлээгүй бол барилгын салбар ганцаараа уналттай байсан нь 0.4 нэгж хувиар эдийн засгийг сааруулах нөлөө үзүүлжээ.

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлтийг голлон бүрдүүлж байсан уул уурхайн салбарын өсөлт Оюу толгойн ил уурхайгаас олборлож буй зэсийн баяжмал дахь агууламжийн хэмжээ түр хугацаанд буурч байгаатай холбоотойгоор 2016 оны сүүлийн хагасаас эхлэн саарах хандлагатай болж байна. Гэхдээ 4-р улиралд олон улсын зах зээл дээр манай гол экспортын түүхий эдийн үнэ нэмэгдэж, зарим нүүрсний уурхай олборлолтоо сэргээсэн нь нүүрс, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний олборлолт огцом өсөхөд нөлөөлж, улмаар уул уурхайн салбарын өсөлт эерэг (1.9 хувь) гарчээ. Харин газрын тос, алт, зэсийн баяжмалын үйлдвэрлэл биет хэмжээгээрээ буурч, нийт уул уурхайн салбарын өсөлтийг сааруулах нөлөө үзүүлэв.

Уул уурхайн салбарт гарсан энэхүү нөлөө нь уул уурхайн бус салбарууд, тэр дундаа тээврийн салбарт эерэгээр нөлөөлөв. Тухайлбал, тайлант улиралд авто болон төмөр замын ачаа тээвэр нэмэгдсэнээр тээвэр агуулахын салбарын өсөлт өмнөх улирлуудаас эрчимжиж, 30 гаруй хувьд хүрсэн бөгөөд эдийн засгийн өсөлтийг бүрдүүлсэн гол салбар болжээ.

Хөдөө аж ахуйн салбар тайлант улиралд 13 орчим хувиар өсөхөд газар тариалан голлох нөлөө үзүүлжээ. Тодруулбал, 2016 онд цаг агаарын байдал харьцангуй таатай байснаар хураан авсан үр тариа, улаан буудайн ургацын хэмжээ ганд нэрвэгдээд байсан өмнөх оны гүйцэтгэлээс 2.2 дахин нэмэгдэв. Харин мал аж ахуйн

Зураг II.2.2.1

ДНБ-ий жилийн өсөлт

Эх сурвалж: ҮСХ

Хүснэгт II.2.2.1

Салбаруудын жилийн ба улирлын өсөлт /2016Q4 өсөлтөд эзлэх хувиар эрэмбэлсэн/

	2015 YoY %	2016 YoY %	2016Q4 YoY %	2016Q4 QoQ %*
ДНБ-ий өсөлт	**2.4**	**1.0**	**7.8**	**9.0**
Тээвэр ба агуулах	4.5	14.8	31.7	26.9
Хөдөө аж ахуй	10.7	4.8	13.3	3.9
Худалдаа	-7.0	-3.2	6.8	16.0
Бүт. татвар	-22.7	0.8	19.7	-4.4
Бусад үйлчилгээ	5.9	1.1	4.9	-7.9
Боловсруулах	1.3	-1.8	10.4	4.2
Уул уурхай	14.1	0.7	1.9	9.7
Эрчим хүч	3.1	4.1	4.4	3.9
Мэдээлэл, холбоо	-2.1	-0.5	0.2	-1.2
Барилга	-0.6	-15.9	-7.8	51.0

** улирлын хэлбэлзлийг арилгасан*

Зураг II.2.2.2

Аж үйлдвэрлэлийн салбаруудын өсөлт

Эх сурвалж: ҮСХ

[10] Бусад үйлчилгээний салбарын өсөлтийн дийлэнх хувийг санхүү даатгал зуучлалын үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээ бүрдүүлдэг.

хувьд 2016 онд өмнөх оноос 2.8 хувиар илүү буюу 19.7 сая төл мал бойжсон бөгөөд хүнсэнд хэрэглэхээр нядалсан малын тоо өмнөх оны өндөр түвшинд хүрээгүй тул нийт салбарын өсөлтөд төдийлөн эерэг нөлөө үзүүлээгүй байна.

Эдийн засгийн идэвхжил болон орлогын бууралтыг даган сүүлийн 2 жилийн турш буурч байсан худалдааны салбар тайлант улиралд 6.8 хувиар өсөв. Үүнд: уул уурхайн томоохон төслүүдэд ханган нийлүүлэх машин механизм, тоног төхөөрөмж борлуулагчдын орлого нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн гэж үзэж байна. Худалдаааны салбарын борлуулалтын орлого тайлант хугацаанд нэрлэсэн дүнгээр 12.3 хувиар өссөний 6.6 нэгж хувийг жижиглэн худалдаа, үлдсэн 5.7 нэгж хувийг бөөний худалдааны орлогын өсөлт бүрдүүлжээ.

Дотоодын үйлдвэрлэлийн идэвхжил саарахтай зэрэгцээд 2013 оны сүүлчээс хойш уналттай байсан бүтээгдэхүүний цэвэр татвар тайлант улиралд бодит дүнгээрээ 19.7 хувиар өсөхөд улсын төсөвт дотоодын болон импортын бараа, бүтээгдэхүүнд ногдуулсан НӨАТ, импортын гаалийн албан татварын орлого бүрдүүлэлт нэмэгдсэн нь нөлөөлжээ. Нэг талаас НӨАТ-ын татвар төлөгчдийн суурь нэмэгдэж байгаагаас гадна импорт агших далайц багасч ийнхүү бараа, бүтээгдэхүүний татварыг нэмэгдүүлэх нөлөө үзүүлжээ. Харин тайлант улиралд автобензин, дизель түлшний татварын хувь хэмжээг бууруулсан нь онцгой албан татварын орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлөв.

Өмнөх жилүүдэд төсвийн хөрөнгө оруулалт, төсөвтэй адилтгах зардлын санхүүжилт, орон сууцны дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийн нөлөөгөөр өсөлт нь дэмжигдэж байсан барилгын салбар өрхүүдийн орон сууц худалдан авах чадвартай холбоотойгоор идэвхжил нь саарсан хэвээр байна. Тодруулбал, тайлант улиралд тус салбарын 7.8 хувийн уналтыг орон сууцны барилга угсралтын ажил удааширсан нь дангаараа тайлбарлаж байгаа бол орон сууцны бус зориулалттай болон эрчим хүч, авто замын зориулалттай инженерийн барилга байгууламжийн ажил тайлант улиралд эрчимжиж, салбарын өсөлтөд эерэг нөлөө үзүүлжээ.

Зураг II.2.2.3

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл /гол нэр төрлийн бүтээгдэхүүнээр/

Эх сурвалж: ҮСХ, судлаачийн тооцоо

Зураг II.2.2.4

Үйлчилгээний салбаруудын өсөлт

Эх сурвалж: ҮСХ

II.2.3 Потенциал үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн зөрүү

Потенциал үйлдвэрлэл[11]-ийн өсөлт 2010-2013 онуудад 10 хувь давж эрчимжиж байсан бол 2014 оноос эхлэн хөрөнгө оруулалт саарснаас шалтгаалан огцом удаашрах хандлага хадгалагдсаар байна. Потенциал өсөлт сүүлийн улирлуудад 2-3 орчим хувь байлаа (Зураг II.2.3.1).

Зураг II.2.3.1

Потенциал үйлдвэрлэлийн өсөлт

Эх сурвалж: судлаачийн тооцоо

Нийт үйлдвэрлэл 2011-2013 онуудад потенциал хэмжээнээсээ давж, уул уурхайн бус салбарын нөлөөгөөр үйлдвэрлэлийн зөрүү[12] эерэг байсан. Харин сүүлийн 2 жилийн турш уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл агшиж буй голлох нөлөөгөөр дотоодын нийт үйлдвэрлэл потенциал түвшнээсээ бага буюу үйлдвэрлэлийн зөрүү сөрөг түвшинд байна. Уул уурхайн салбарын хувьд 2014 оны сүүлийн хагасаас эхлэн потенциал түвшнээсээ давж үйлдвэрлэж байна. Нүүрсний үнэ өсч, улмаар уул уурхай болон тээвэр, худалдаа зэрэг салбаруудын өсөлтийг тэлсэн нь 2016 оны 4-р улиралд үйлдвэрлэлийн зөрүүг нэмэгдүүлэх нөлөө үзүүлэв (Зураг II.2.3.2).

Зураг II.2.3.2

Үйлдвэрлэлийн зөрүү

Эх сурвалж: судлаачийн тооцоо

[11] 1) Цэвэр статистик тооцооллын HP фильтр, 2) үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн мэдээллийг ашиглан тооцсон үйлдвэрлэлийн функц болон 3) макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн мэдээлэл, тэдгээрийн хоорондын хамаарлыг ашигладаг олон хувьсагчийн Калман фильтр гэсэн 3-н аргачлалаар тооцсон.

[12] Калман фильтрээр тооцсон.

II.3 Монгол улсын нэгдсэн төсөв, Засгийн газрын өр

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл: 2016 онд төсвийн нийт зардал төсвийн тодотголтой харьцуулахад 98.2 хувийн гүйцэтгэлтэй гарч, өнгөрсөн оноос 33.4 хувиар өссөн бол тэнцвэржүүлсэн орлого 109.4 хувийн гүйцэтгэлтэй гарч, өнгөрсөн оноос 2.2 хувиар буурсан байна. Ингэснээр нийт алдагдал төсвийн тодотголоос 678 тэрбум төгрөгөөр буурч дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 15.3 хувьтай гарлаа. Улсын өр нэмэгдсэнтэй холбоотой зээлийн хүүний зардал 2016 онд өмнөх оноос 35.1 хувиар өссөнөөр ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хувь 1.1 нэгж хувиар нэмэгдэв.

Хүснэгт II.3.1

Төсвийн үзүүлэлтүүд

тэрбум төгрөг	2015 Гүй.	2016 Гүй.	Өсөлтийн хурд /хувь/	Гүйцэтгэлийн хувь
Тэнцвэржүүлсэн орлого	5981	5852	-2.2	109.4
Татварын орлого	5119	4997	-2.4	110.8
Импорттой холбоотой	1348	1421	5.4	-
Уул уурхайтай холбоотой	652	325	-50.1	-
Татварын бус орлого	862	855	-0.8	102.1
Нийт зардал	7138	9520	33.4	98.2
Анхдагч зардал	6407	8532	33.2	98.7
Хүүний зардал	731	988	35.1	94.3
Нийт тэнцэл	-1157	-3668	217.0	
ДНБ-д эзлэх хувь	-5.0%	-15.3%		
Анхдагч тэнцэл	-426	-2680	564.0	
ДНБ-д эзлэх хувь	-1.8%	-11.2%		

Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн зардал, орлогын бүрэлдэхүүн[13]:

Төсвийн зардлыг ангиллаар нь авч үзвэл өмнөх онтой харьцуулахад хөрөнгийн зардал болон цэвэр зээл бусад зардлаас илүү өссөн тул нийт зардалд эзлэх хувь нь нэмэгджээ. Хөрөнгийн зардал өсөхөд вексел, концессийн эргэн төлөлттэй холбоотой зардал, эргэж төлөгдөх цэвэр зээл өсөхөд засгийн газраас хэрэгжүүлсэн "Сайн" хөтөлбөрийн хүрээнд олгосон эргэж төлөгдөх зээл голлон нөлөөлсөн. Хөрөнгийн зардал 2016 онд өнгөрсөн оноос 72.2 хувиар, вексел, концессийн эргэн төлөлттэй холбогдох зардлыг хасч тооцвол 16.7 хувиар өссөн байна.

Зураг II.3.1

Төсвийн зардлын бүрэлдэхүүн

Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн тодотголд тусгасан дүнтэй харьцуулахад татварын орлого бүрэлдэхүүн тус бүрээр төлөвлөснөөс өндөр гүйцэтгэлтэй, татварын бус орлого 88 хувийн гүйцэтгэлтэй гарсан бөгөөд орлогын бүрэлдэхүүн хэсгүүд өнгөрсөн онтой харьцуулахад төдийлөн өөрчлөгдсөнгүй. Харин төсвийн орлогыг өнгөрсөн онтой харьцуулбал 2.2 хувиар буурахад ашигт малтмалын нөөц ашиглалтын төлбөрийн орлого 320 орчим тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөллөө.

Зураг II.3.2

Төсвийн орлогын бүрэлдэхүүн

Эх сурвалж: Сангийн яам

[13] 2017 оны батлагдсан төсөв

Төсвийн төлөв ба төсвийн импульс: Монгол улсын эдийн засгийн өсөлт, төсвийн орлого бүрдүүлэлт нь уул уурхай, эрдэс баялгийн үнийн хэлбэлзлээс ихээхэн хамаардаг тул нийт тэнцвэржүүлсэн тэнцлийг үйлдвэрлэлийн зөрүүгээр засварлаж төсвийн төлөвийг тооцов.

Мөчлөгөөс үүдэлтэй төсвийн алдагдлын нөлөө 2015 онд ДНБ-ий 0.3 нэгж хувь байсан бол 2016 онд 0.6 нэгж хувь болж өссөн. Мөчлөгийн нөлөө бага байгаагаас нийт тэнцэл болон төсвийн төлөвөөр тооцсон төсвийн импульс сүүлийн жилүүдэд ойролцоо утгатай байна. 2016 онд төсвийн импульс 10.0 хувьтай гарсан нь төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь 2015 онтой харьцуулахад дээрх хэмжээгээр нэмэгдсэн буюу төсвийн тэлэх бодлого хэрэгжсэнийг илэрхийлж байна.

Зураг II.3.3

Төсвийн төлөв ба төсвийн импульс, улирлаар

Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн төлөвийг улирлаар харвал 2016 онд Засгийн газраас хэрэгжүүлсэн "Сайн" хөтөлбөр, концесс, векселийн эргэн төлөлттэй холбоотойгоор 3 болон 4 дүгээр улиралд төсвийн алдагдал харгалзан тухайн улирлын ДНБ-ий 13.9 хувь, 24.1 хувийг эзэлж байлаа. Үүний нөлөөгөөр 2016 оны 3 дугаар улирлын жилийн импульс 8.8 хувь (нийт тэнцлээр тооцвол 9.6), 4 дүгээр улирлын жилийн импульс 19.2 хувьд хүрч огцом өссөн байна.

Зураг II.3.4

Төсвийн төлөв ба төсвийн импульс, улирлаар

Эх сурвалж: Сангийн яам

Өрийн эргэн төлөлт, шинээр авсан зээлийн харьцаа[14]:

Сүүлийн жилүүдэд өрийн эргэн төлөлт, шинээр авсан зээлийн харьцаа дийлэнхдээ 100 хувиас давж байв. Тухайлбал ОУВС-тай байгуулсан "Стэнд бай" хөтөлбөрийн зээл, Чингис бондын нөлөөгөөр 2009, 2012 онд огцом өндөр дүнтэй гарсан байна. МУ-ын Засгийн газар 2016 онд 5713.3 тэрбум төгрөгийн зээл болон үнэт цаас шинээр гаргаж, зээл, үнэт цаасны үндсэн төлбөр болон зээлийн үйлчилгээний төлбөрт нийт 2906.5 тэрбум төгрөг төлсөн. Өрийн эргэн төлөлт, шинээр авсан зээлийн харьцаа өмнөх оноос 87 нэгж хувиар огцом өсч 197 хувьд хүрсэн. Энэ нь сүүлийн жилүүдэд төсвийн анхдагч тэнцэл их хэмжээний алдагдалтай гарч түүнийг өрөөр санхүүжүүлж байсныг харуулж байна.

Зураг II.3.5

Өрийн эргэн төлөлт, шинээр авсан зээлийн харьцаа

Эх сурвалж: Сангийн яам

[14] Тайлант онд засгийн газраас борлуулсан нийт үнэт цаас болон шинээр авсан зээлийн хэмжээг, тус хугацаанд төлсөн үнэт цаас, зээлийн эргэн төлөлт болон зээлийн үйлчилгээний төлбөрийн нийт дүнд харьцуулан "Өрийн эргэн төлөлт, шинээр авсан зээлийн харьцаа"-г тооцов.

Засгийн газрын нийт өр: 2016 оны 9 дүгээр сард "Төсвийн тогтвортой байдлын тухай хууль"-д оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг 2016 оны төсвийн жилд 88 хувь, 2017 оны төсвийн жилд 85 хувь, 2018 оны төсвийн жилд 80 хувь, 2019 оны төсвийн жилд 75 хувиас хэтрэхгүй байхаар заасан байна. Төсвийн хүрээний мэдэгдлээр 2018-2019 онд өрийн үлдэгдлийн хэмжээ нэрлэсэн байдлаар харгалзан жилийн 2.8, 4.3 хувиар өсөх хэдий ч ДНБ-ий өсөлтөөс шалтгаалан 2017-2019 онд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ энэхүү хуульд заасан шаардлагыг хангахаар байгаа юм (Хүснэгт II.3.2).

Хүснэгт II.3.2

Засгийн газрын нийт өр, өнөөгийн үнэ цэнээр

	2015	2016	2017	2018	2019
тэрбум төгрөг	Гүй.	Гүй.	ТХМ	Төс.	Төс.
Засгийн газрын нийт өр	12124	18964	22197	22818	23799
ДНБ-д эзлэх хувь	52.4	79.4	84.8	79.9	74.8
Үүнээс: Гадаад өр	34.1	51.6	-	-	-
Өрийн хязгаар/ДНБ	58.3	88.0	85.0	80	75

Эх сурвалж: Сангийн яам

Шигтгээ 1. Төсвийн төлөв

Төсвийн нийт тэнцэл нь бодлого боловсруулагчдын шийдвэрээс гадна гэнэтийн болон түр зуурын шинжтэй бусад хүчин зүйлсээс (эдийн засгийн мөчлөг, байгалийн баялгийн үнийн мөчлөг г.м) хамаардаг. Эдийн засгийн мөчлөгийн болон бүтцийн хүчин зүйлсийн нөлөөг хасч тооцсон төсвийн тэнцлийг "төсвийн төлөв" гэдэг. Монгол улсын Засгийн газар 2010 оноос "Гол нэр төрлийн эрдэс баялаг"-ийн урт хугацааны үнэнд суурилсан тэнцвэржүүлсэн тэнцэл тооцох болсон нь бүтцийн тэнцлийн нэг хэлбэр юм. Монгол улсын хувьд "Гол нэр төрлийн эрдэс баялаг" гэдэгт тухайн жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа тухайн төрлийн эрдэс баялагийг хамааруулах бөгөөд үүнд 2014 оныг хүртэл зэс болон нүүрс багтаж байсан. 2014 оны 3 дугаар улирлаас хойш нүүрсний үнэ тасралтгүй буурснаар сүүлийн 2 жилийн хугацаанд нүүрсний орлого төсвийн орлогын гурваас доош хувийг бүрдүүлж, сүүлийн 2 жилд "Гол нэр төрлийн эрдэс баялаг"-т зэс дангаар багтсан.

Төсвийн төлөвийг тооцохын тулд тэнцвэржүүлсэн/бүтцийн тэнцлээ мөчлөгийн хэсэг болон мөчлөгийн нөлөөг арилгасан хэсэгт хуваана.

$$\boldsymbol{SB = CB + CASB,} \qquad (1)$$

SB- бүтцийн тэнцэл, CB – мөчлөгийн хэсэг (мөчлөгт автоматаар хариу үйлдэл үзүүлдэг хэсэг), CASB- мөчлөгийн нөлөөг арилгасан бүтцийн тэнцэл. Эдийн засгийн мөчлөгийн болон бүтцийн нөлөөг арилгасан төсвийн нийт орлого (R^{CAS}) болон нийт зарлагын (G^{CAS}) зөрүүгээр мөчлөгийн нөлөөг засварласан бүтцийн тэнцэл (CASB) гарна.

$$\boldsymbol{CASB = R^{CAS} - G^{CAS},} \qquad (2)$$

Эдийн засгийн мөчлөгийн нөлөөг засварлахдаа үйлдвэрлэлийн зөрүүг ашигладаг. Ингэхдээ потенциал ДНБ (Y^*) болон бодит ДНБ (Y)-ий харьцаагаар засварлах ба орлого болон зарлагын мэдрэмж ($E_{R,Y}, E_{G,Y}$)[15] нь мөчлөгийн нөлөө төсөвт хэр хүчтэй байгааг харуулна[16].

$$\boldsymbol{R^{CAS} = R^{S}(\frac{Y^*}{Y})^{E_{R,Y}},} \qquad (3)$$

$$\boldsymbol{G^{CAS} = G^{S}(\frac{Y^*}{Y})^{E_{G,Y}}} \qquad (4)$$

Нийт тэнцвэржүүлсэн тэнцэл/төсвийн төлөвийн ДНБ-д эзлэх хувийн өөрчлөлтөөр төсвийн импульсийг хэмжинэ. Төсвийн импульс эерэг (сөрөг) утгатай байх нь төсвийн бодлого өмнөх үетэй харьцуулахад суларч (чангарч) байгааг илэрхийлэхээс гадна төсвийн бодлогын далайцыг харуулдаг.

[15] Тооцоололд татварын орлогын мэдрэмж 1, татварын бус орлого болон зарлагын мэдрэмж 0 гэж үзсэн.

[16] Б.Цэнд-Аюуш, 2013. "Төсвийн бодлогын төлөв ба мөчлөгийн нөлөөг засварласан бүтцийн тэнцэл." *Монголбанкны судалгааны ажлын товхимол – 8, 190-206*

II.4 Хөдөлмөрийн зах зээл

Тайлант улиралд ажиллах хүчний оролцооны түвшин буурсан боловч өмнөх оны мөн үеэс эдийн засгийн ихэнх салбаруудад ажиллагсадын тоо өслөө.

II.4.1 Ажил эрхлэлт, ажилгүйдэл

Тайлант улиралд ажиллах хүчний оролцооны түвшин буурч, ажилгүйдлийн түвшин өслөө.

Ажиллах хүчний оролцооны түвшин 2016 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар, өмнөх улирлаас 1.2 хувиар буурчээ. Тайлант улиралд хөдөлмөрийн насны хүн ам[17] 128’306 (6.7 хувь)-иар өссөн байхад эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 75’786 (6.5 хувь)-иар нэмэгдсэн нь ажиллах хүчний оролцооны түвшин буурч 60.4 хувьд хүрэхэд нөлөөллөө.

Ажилгүйдлийн түвшин 2016 оны сүүлийн улиралд 8.6 хувь болсон нь өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өндөр байна. Тайлант улиралд ажил эрхлэлтийн өсөлт ажиллах хүчний өсөлтөөс бага байгаагаас ажилгүйдлийн түвшин нэмэгдлээ. Тухайлбал ажиллагсдын тоо 2016 оны 4 дүгээр улиралд 1’132’843 болж өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар өссөн ч ажилгүйчүүд 107’003 болж өмнөх оноос 10.9 хувиар нэмэгджээ. Хөдөлмөрийн биржид бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд орсон иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 26 хувь (1’915)-иар буурсан байна.

Ажиллагсдын тооны өсөлт импортын орц ихтэй салбарт бага, импортын орц багатай салбарт илүү байна. Тухайлбал ажиллагсдын тоо барилгын салбарт 23.4% (18’053), тээвэр ба агуулахын салбарт 13.2% (9’348)-иар буурсан бол боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 29.2% (20’040), төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа албан журмын нийгмийн хамгааллын салбарт өмнөх оноос 34% (19’666)-иар нэмэгдлээ.

Ажиллагсдыг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар авч үзвэл хувиараа хөдөлмөр эрхлэгч (44’409), нөхөрлөл, хоршооны гишүүд (19), мал аж ахуй эрхлэгчдийн тоо (25’940) буурсан бол цалин хөлстэй ажиллагч (113’426), ажил олгогч (7’277), өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчид (12’939) болон бусад хэлбэрийн хөдөлмөр эрхлэгчид өссөн байна.

Хүснэгт II.4.1.1

Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд

Он	2012	2013	2014	2015	2016 Q1	2016 Q2	2016 Q3	2016 Q4
Ажиллагсад (мян. хүн)	1018.2	1038.2	1040.7	1067.6	1089.3	1131.8	1144.4	1132.8
жилийн өсөлт	*-0.8%*	*2.0%*	*0.2%*	*2.6%*	*-2.5%*	*-1.2%*	*2.2%*	*6.1%*
Хөдөө аж ахуй	318	305	322	335	320	314	385	352
Аж үйлдвэр	182	205	224	207	210	233	200	209
Худалдаа	137	152	174	154	166	171	165	173
Үйлчилгээ	381	377	384	371	393	414	394	399
Ажилгүй иргэд (мян. хүн)	87.8	87.2	87.0	96.5	143.5	131.9	118.9	107.0
жилийн өсөлт	*13.4%*	*-0.6%*	*-0.3%*	*10.9%*	*62.0%*	*35.5%*	*57.0%*	*10.9%*
Ажиллах хүчний оролцоо,	61.6	60.9	60.3	60.5	60.0	60.2	61.6	60.4
жилийн өөрчлөлт	*-2.6*	*-0.7*	*-0.6*	*0.2*	*-1.5*	*-2.6*	*0.2*	*-0.1*
Ажилгүйдэл, %	7.9	7.8	7.7	8.3	11.6	10.4	9.4	8.6
жилийн өөрчлөлт	*0.9*	*-0.1*	*-0.1*	*0.6*	*4.2*	*2.6*	*3.1*	*0.3*

Эх сурвалж: ҮСХ[20]

Зураг II.4.1.1

Шинээр ажилд орсон иргэдийн тоо буурчээ.

Эх сурвалж: ҮСХ

Зураг II.4.1.2

Эдийн засгийн салбаруудад ажиллагсадын тоо өсчээ.

Эх сурвалж: ҮСХ

[17] Монгол улсын “Хөдөлмөрийн тухай” хуулинд хөдөлмөрийн насны хүн амд 15-59 насны хүн амыг хамруулна гэж заасан. Харин улсын бүртгэл статистикийн ерөнхий газрын хувьд олон улсын ангиллаар буюу 15-аас дээш насны нийт хүн амын тоогоор хөдөлмөрийн насны хүн амыг төлөөлүүлэн авч үздэг.

[20] Ажиллах хүчний судалгаа

II.4.2 Цалин, бүтээмж

Нийт хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт 2012 оноос хойш хамгийн бага түвшинд хүрлээ.

Тайлант улиралд бодит ДНБ-ийг[18] нийт ажиллагсадын тоонд хуваах тооцсон хөдөлмөрийн бүтээмжийн жилийн өөрчлөлт 2016 оны сүүлийн улиралд -4.8 хувь боллоо. Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт ийнхүү буурахад бодит ДНБ (0.9%) өссөн байхад ажиллагсадын тоо (6.1%) өссөн нь голлон нөлөөллөө. (Зураг II.4.2.1).

Зураг II.4.2.1

Хөдөлмөрийн бүтээмж өсөлт буурчээ.

Эх сурвалж: ҮСХ, судлаачийн тооцоолол

Үйлдвэрлэлийн нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай хөдөлмөрийн дундаж зардлыг илэрхийлдэг гол үзүүлэлт болох нэгж хөдөлмөрийн зардал[19] (НХЗ) 2016 оны 4 дүгээр улиралд өслөө. Үүнд нэрлэсэн цалингийн өсөлт (8.6%) хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөөс (1.7%) өндөр байсан нь нөлөөлөв. Хөдөө аж ахуйн салбарын НХЗ-н өсөлт бусад салбарынхаас бага өсөлттэй байгаа нь тус салбарын цалингийн өсөлт бага байгаатай холбоотой. (Зураг II.4.2.2).

Зураг II.4.2.2

Нэгж хөдөлмөрийн зардлын өсөлт буурлаа.

Эх сурвалж: ҮСХ, судлаачийн тооцоолол

Улсын нэрлэсэн дундаж цалин 2016 оны 4 дүгээр улиралд өмнөх оноос 8.6 хувиар нэмэгдэж, 942’900 төгрөгт хүрлээ. Үүнийг эдийн засгийн салбаруудаар авч үзвэл урлаг үзвэр тоглоом наадам (-7.1%), мэдээлэл холбооны (-6.6%) салбарын нэрлэсэн цалин буурсан бол боловсруулах үйлдвэр (21.3%), олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа (16%), мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарын (9.9%) нэрлэсэн цалин өмнөх оны мөн үеэс өссөн байна. (Зураг II.4.2.3).

Зураг II.4.2.3

Өрхийн цалингийн орлого буурлаа.

Эх сурвалж: ҮСХ, судлаачийн тооцоолол

[18] Бодит ДНБ-ийг тооцохдоо тухайн улирлын бодит ДНБ дээр өмнөх 3 улирлын бодит ДНБ-ийг нэмж тооцсон.

[19] Нэгж хөдөлмөрийн зардал = Ажиллагсад*Нэрлэсэн цалин/Бодит үйлдвэрлэл = Нэрлэсэн цалин/Хөдөлмөрийн бүтээмж, зэрэгцүүлэх үнээр

II.5 Мөнгө, санхүүгийн зах зээл

II.5.1 Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

Мөнгөний үзүүлэлтүүдийн өсөлт 2016 оны IV улиралд үргэлжлэн нэмэгдсэн бол зээлийн өсөлт өмнөх улирлаас буурав. Засгийн газрын банкны системээс авсан цэвэр зээлийн өсөлт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голчлон тайлбарлаж байна. М2 мөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.2 хувиар, банкуудын зээлийн үлдэгдэл 6.1 хувиар өсөв.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нэмэгдэж байгаа нь дотоод цэвэр актив өмнөх жилийн мөн үеэс 17 хувиар өссөнөөс шалтгаалсан. Төсвийн алдагдал тайлант улиралд өмнөх жилийн мөн үеэс 8 дахин нэмэгдэж 1.6 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд гадаад санхүүжилт хомс байгаа нөхцөлд төсвийн алдагдлыг дотоод бондоор санхүүжүүлэх шаардлага нэмэгдсэн. Иймд Засгийн газар цэвэр дүнгээр 850 тэрбум төгрөгийн дотоод бондыг арилжаалж төсвийн алдагдлыг санхүүжүүлсэн нь Засгийн газрын цэвэр зээл мөнгөний нийлүүлэлтийг 11 нэгж хувиар өсгөх нөлөө үзүүлсэн. Түүнчлэн ипотекийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт өсч буй нь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж байна.

Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт өсч буй шалтгааныг банкны системийн эх үүсвэр талаас харвал гадаад валютын хадгаламж болон харилцах дансны жилийн өсөлт[21] 22 хувь, 17 хувьд тус тус хүрсэн нь мөнгөний нийлүүлэлтийг 14 нэгж хувиар нэмэгдүүлсэн. Энэ өсөлтийг эдийн засгийн агентуудаар задлан харвал иргэдийн гадаад валютаар байршуулсан харилцах данс, хадгаламжийн өсөлт аж ахуйн нэгжүүдийнхээс илүү хурдтай нэмэгдсэн байна. Харин мөнгөний нийлүүлэлтийн 60 орчим хувийг бүрдүүлдэг төгрөгийн харилцах, хадгаламж жилийн 20 хувиар өссөн нь мөнгөний нийлүүлэлтийг 6.2 нэгж хувиар нэмэгдүүлсэн. Төгрөгийн харилцах данс, хадгаламжийн 81 хувийг иргэдийн харилцах, хадгаламж эзэлж байна.

Зураг II.5.1.1

М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал

Эх сурвалж: Монголбанк

Зураг II.5.1.2

М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, пассив тал

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт II.5.1.3

Мөнгөний нийлүүлэлт: актив, пассив тал

Тэрбум төгрөгөөр	2013	2014	2015	2016
Гадаад цэвэр актив	760	-2021	-4169	-4591
Дотоодын цэвэр актив	8693	12656	14218	16668
Мөнгөний нийлүүлэлт /М2/	9453	10635	10049	12077
М1 мөнгө	2093	1817	1685	2090
Банкнаас гадуурх мөнгө	582	499	459	563
Харилцах данс,₮	1511	1317	1227	1527
Бараг мөнгө	7360	8818	8364	9986
Хадгаламж,₮	4911	5410	5434	5767
Хадгаламж, $	1475	1969	1948	2781
Харилцах данс, $	974	1439	982	1438

Эх сурвалж: Монголбанк

[21] Ханшийн нөлөөг арилгаж тооцсон жилийн өсөлт

Санхүүгийн байгууллагуудын[22] зээл тайлант улиралд 1 хувиар нэмэгдэж 19.4 их наяд төгрөг хүрэв. Үүний 49 хувийг банкууд өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 15 хувийг Хөгжлийн банк, 18 хувийг Монголбанкны санхүүжилттэй ипотекийн зээл, 17 хувийг Засгийн газрын санхүүжилттэй зээл бүрдүүлж байна. Тайлант улиралд Хөгжлийн банкнаас аж ахуйн нэгжүүдэд олгосон 3 их наяд төгрөгтэй тэнцэх дүнтэй зээлийг нэгдсэн төсөвт шилжүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын зээл нэмэгдсэн. Харин банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл жилийн 5 хувиар нэмэгдэж, нийт санхүүгийн байгууллагуудын зээлийг 2 нэгж хувиар өсгөх нөлөө үзүүлсэн. Уг өсөлтийн дийлэнх хэсгийг хэрэглээний зориулалттай олгосон зээл эзэлж байна.

Хадгаламжийн байгууллагуудын[23] зээлийн үлдэгдэл тайлант улиралд өмнөх жилийн мөн үеэс 6.1 хувиар өссөн. Секторoор авч үзвэл иргэдийн жижиг, дунд үйлдвэрлэлд олгосон зээлээс бусад зээл өмнөх жилийн мөн үеэс нэмэгдсэн. Ипотекийн зээл тайлант улиралд жилийн 30 хувиар нэмэгдсэн нь суурь үеийн нөлөө, ипотекийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт үргэлжлэн олгогдож эхэлсэнтэй холбоотой. Хэрэглээний зээлийн үлдэгдэл тайлант улиралд жилийн 11 хувиар тэлж, зээлийн өсөлтийг тэтгэсэн хэвээр байна. Хэрэглээний зээл[24] ийнхүү өсөхөд гол нөлөөлсөн бүрэлдэхүүн нь сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа тэтгэврийн болон цалингийн зээл юм. Эдийн засгийн идэвхжил саарч, өрхийн нэрлэсэн болон бодит орлого буурсаар байгаа нь хэрэглээний зориулалттай зээлийг нэмэгдүүлэх гол шалтгаан болж байна.

Эдийн засгийн голлох салбаруудаар зээлийг ангилвал ихэнх салбаруудад зээлийн өсөлт буурсаар байна. Үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл жилийн 29 хувиар буюу нийт зээлийг 3.3 нэгж хувиар нэмэгдүүлсэн нь салбарууд дотор хамгийн өндөр нөлөөтэй байв. Ипотекийн зээл өсч байгаа нь үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл нэмэгдэх шалтгаан болов. Харин барилга, уул уурхайн салбарын зээл хумигдсан хэвээр байгаа нь нийт зээлийн өсөлтийг 1.4 нэгж хувь, 3 нэгж хувиар тус тус бууруулах нөлөөтэй байв. Эдийн засгийн өсөлт саарч, эдгээр салбаруудад олгосон зээлийн хугацаа хэтрэлт нэмэгдэж, чанаргүй болж байгаагаас тухайн салбаруудад олгох зээлийн дүн буурсаар байна. Түүнчлэн боловсруулах болон худалдааны салбарын чанаргүй, хугацаа хэтэрсэн

Зураг II.5.1.4

Санхүүгийн байгууллагуудын нийт зээлийн жилийн өсөлт, түүний бүрэлдэхүүн

Эх сурвалж: Монголбанк

Зураг II.5.1.5

Хадгаламжийн байгууллагуудын зээлийн жилийн өсөлт, секторoор

Эх сурвалж: Монголбанк

Зураг II.5.1.6

Хадгаламжийн байгууллагуудын зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбарын ангиллаар

Эх сурвалж: Монголбанк

[22] Санхүүгийн байгууллагууд нь банк, хадгаламж, зээлийн хоршоо, МИК, Хөгжлийн банк болон банк бус санхүүгийн байгууллагаас бүрддэг.
[23] Хадгаламжийн байгууллага нь банк болон хадгаламж, зээлийн хоршооноос бүрдэнэ.
[24] Хэрэглээний зээл нь цалингийн, хэрэглээний, тэтгэврийн, картын болон хадгаламж барьцаалсан зээлээс бүрддэг.

зээлийн хэмжээ буурахгүй хэвээр байгаагаас шалтгаалан эдгээр салбаруудын зээлийн хэмжээ төдийлөн нэмэгдэхгүй байна.

Сүүлийн 4 улирал дараалан шинээр олгосон зээлийн өсөлтийг хэрэглээний зориулалттай олгосон зээл голлон тайлбарлаж байна. Банкуудын шинээр олгосон зээлийн хэмжээ 2016 оны IV улиралд жилийн 38 хувиар өссөн. Өрхийн орлого хумигдсан хэвээр байгаагаас шинээр олгосон цалингийн зээлийн дүн жилийн 60 хувь, хэрэглээний зориулалттай зээл жилийн 43 хувиар өссөн. Энэ нь банкуудын шинэ зээл олголтыг 28 хувиар нэмэгдүүлэв.

Банкуудын чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хувь тайлант улиралд 2015 оны эцэстэй харьцуулахад 2 нэгж хувиар өсч 16 хувьд хүрсэн. Эдийн засгийн салбаруудаар авч үзвэл уул уурхай барилга, үл хөдлөх хөрөнгийн салбарт олгосон зээлийн хугацаа хэтрэлт нэмэгдсэн. Нийт хугацаа хэтэрсэн зээлийн 66 хувийг дээрх гурван салбар дангаараа эзэлж байна. Харин нийт чанаргүй зээлийн 51 хувийг уул уурхай болон худалдааны салбарын чанаргүй зээл бүрдүүлж байна. Сүүлийн 8 улирал дараалан өсөлттэй байсан уул уурхайн салбарын чанаргүй зээлийн дүн тайлант улиралд өмнөх улирлаас 37 хувиар багассан.

Зураг II.5.1.7

Банкуудын шинээр олгосон зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбарын ангиллаар

Эх сурвалж: Монголбанк

Зураг II.5.1.8

Банкуудын чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл, тухайн салбарын зээлд эзлэх хувиар

Эх сурвалж: Монголбанк

II.5.2 Хүү

Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөлөөс 2016 оны 12 дугаар сард бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 14 хувьд хүргэх шийдвэрийг гаргав. Инфляци ирэх онд зорилтот түвшнээс доогуур байж, эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт бага байхаар хүлээгдэж байгаагийн зэрэгцээ дунд хугацаандаа төсвийн сахилга бат сайжирч, өрийн тогтвортой байдал хангагдах хүлээлттэй байна. Иймд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бодит секторын идэвхжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор уг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Зураг II.5.2.1

Бодлогын хүү 1 нэгж хувиар буурч, 14 хувьд хүрсэн.

Эх сурвалж: Монголбанк

Богино хугацаат буюу 1 жил хүртэлх хугацаатай засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ны хүү 2016 оны 12 дугаар сард 17.6[25] хувь болж өмнөх улирлаас 2 нэгж хувиар өссөн. ЗГҮЦ-ны хүү нэмэгдэхэд төсвийн алдагдал өсч, ЗГҮЦ-ыг арилжаалах шаардлага огцом нэмэгдсэн нь голчлон нөлөөлөв. Монголбанкаар дамжуулан хийгддэг ЗГҮЦ-ны арилжаагаар 2016 оны 4 дүгээр улиралд нийт 1.1 их наяд төгрөгийн үнэт цаасыг 17 нэгж хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр арилжааллаа.

Зураг II.5.2.2

Богино хугацаат ЗГҮЦ-ны хүү нэмэгдсэн.

Эх сурвалж: Монголбанк

Банкуудын зээл, хадгаламжийн хүү 2016 оны 4 дүгээр улиралд төгрөгийн зээлийн хүү[26] өмнөх улирлаас 0.3 хувиар, төгрөгийн хадгаламжийн хүү 0.1 хувиар тус тус буурав. Бодлогын хүү буурахтай зэрэгцэн төгрөгөөр олгосон зээлийн хүү тайлант улиралд буурсан. Түүнчлэн Монголбанкнаас олгож буй ипотекийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн хэмжээ өмнөх улирлаас нэмэгдсэн нь зээлийн хүү буурахад нөлөөлсөн. Төгрөгөөр байршуулсан хадгаламжийн хүү өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар нэмэгдэж, валютын хадгаламжийн хүү 1.2 хувиар буурсан байна. Зээлийн хүү буурч, хадгаламжийн хүү харьцангуй тогтмол байгаагаас зээл, хадгаламжийн хүүний зөрүү багасч, 6.0 хувьд хүрэв.

Зураг II.5.2.3

Зээл, хадгаламжийн хүүний зөрүү буурав.

Эх сурвалж: Монголбанк

[25] Анхдагч зах дээрх 12 долоо хоног (3 сар)-той ЗГҮЦ-ны хүү

[26] Хөнгөлөлттэй зээлүүдийг оруулж тооцсон зээлийн хүү

Зураг II.5.2.4

Төгрөгийн харьцангуй өгөөж 4 дүгээр улиралд сөрөг түвшинд байв.

Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн харьцангуй өгөөж 2016 оны 4 дүгээр улиралд сөрөг түвшинд тогтож байна. Төгрөгийн ханш тайлант улиралд өмнөх улирлаас 11 хувиар суларсан нь төгрөгийн харьцангуй өгөөж сөрөг байхад голчлон нөлөөлөв.

II.5.3 Валютын ханш

Зураг II.5.3.1

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш

Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн ханш 2016 оны 4 дүгээр улиралд өмнөх үетэй харьцуулахад огцом суларч, 2016 оны 4 дугаар улиралд өмнөх улирлаас 243.6 төгрөг буюу 11.2 хувь, өмнөх оны мөн үеэс 420.1 төгрөг буюу 21.1 хувиар суларч 2413.8 төгрөгт хүрэв /Зураг II.4.3.1/.

Хэдийгээр төгрөгийн ханш сулрах нь импортын барааны үнийг нэмэгдүүлэх ч дотоодын үйлдвэрлэгчдийн бараа, үйлчилгээний үнэ импортынхтой харьцуулахад хямд болж, дотоодын эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нөлөө үзүүлсэн. Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) 2016 оны 4-р улирлын эцэст өмнөх оны мөн үеэс 17.3 хувиар суларч, гадаадын харьцангуй үнэ 1.3 хувиар өссөнөөр бодит ханш өмнөх оны мөн үеэс 18.3 хувиар суларсан байна.

Зураг II.5.3.2

Төгрөгийн голлох валюттай харьцах ханшийн өөрчлөлт

Эх сурвалж: Монголбанк

Манай улсын импортын хэмжээ[27] сүүлийн 12 улирал дараалан бууруад байна. Худалдааны түнш орнуудын мөнгөн тэмдэгт төгрөгийн эсрэг чангарснаар импортын бараа үнэтэй болж улмаар импорт буурахад нөлөөлөв. Ам.доллараар илэрхийлэгдсэн жилийн дүнгээр үзвэл барааны импорт 2013 онд 5.7%, 2014 онд 17.6%, 2015 онд 27.7%, 2016 онд 3.9%-аар буурчээ.

Төгрөгийн нэрлэсэн ханш тайлант хугацааны эцэст ам.долларын эсрэг жилийн 24.8 хувь, еврогийн эсрэг 19.5 хувь, японы иений эсрэг 27.9 хувь, хятадын юаний эсрэг 16.5 хувь, оросын рублийн эсрэг 51.9 хувиар тус тус суларсан байна.

Зураг II.5.3.3

Төгрөгийн бодит үйлчилж буй ханшийн өөрчлөлт

Эх сурвалж: Монголбанк

[27] Нэрлэсэн дүнгээр ам.доллараар илэрхийлсэн СИФ нөхцөлтэй барааны импорт

II.5.4 Үл хөдлөх хөрөнгийн зах зээл

Орон сууц худалдан авах болон түрээслэх үнэ тайлант улиралд уналттай гарлаа. Үндэсний Статистикийн хорооноос тооцон гаргадаг орон сууцны үнийн индекс 2016 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 0.6 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6 хувиар буурсан байна. "Тэнхлэг зууч" компаниас гаргадаг орон сууцны үнийн индекс мөн буурах чиглэлтэй байгаа бөгөөд тайлант улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар буурсан дүнтэй гарчээ. Тодруулбал, хуучин орон сууцны үнэ жилийн өмнөх үеэс 6.4 хувиар, шинэ орон сууцны үнэ 3.0 хувиар хямдраад байна. Харин түрээсийн үнэ 2015 оны 3 дугаар улирлаас эхлэн өсөлттэй байсан бол тайлант улиралд буурлаа. Түрээсийн үнэ 2016 оны 4 дүгээр улирлын байдлаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7 хувиар, өмнөх улирлаас 7.1 хувиар бууруаад байна (Зураг II.5.4.1).

Иргэдийн орон сууц худалдан авах чадвар сул байгаа нь орон сууцны үнэ-орлогын харьцаа болон үнэ-түрээсийн харьцаа нам түвшинд байгаагаас харагдаж байна. Мөн эдгээр үзүүлэлтүүд орон сууцны эрэлт буурч байгааг дохиолж байна. Тайлант улиралд үнэ-түрээс болон үнэ-орлогын харьцаа өмнөх улирлаас өссөн нь түрээсийн үнэ болон өрхийн орлого орон сууцны үнээс илүү хурдтай буурсантай холбоотой байна. Тухайлбал, 2016 оны 4 дүгээр улирлын байдлаар орон сууцны үнэ өмнөх улирлаас 0.6 хувиар, түрээсийн үнэ 7.1 хувиар, өрхийн орлого 10.8 хувиар тус тус буурчээ (Зураг II.5.4.2).

Барилгын өртгийн индексээс харахад барилгын материалын үнэ өсөх хандлагатай байна. Тайлант улиралд барилгын өртгийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 хувиар өссөн бол, улирлын нөлөөллөөр өмнөх улирлаас 0.5 хувиар буурчээ (Зураг II.5.4.3).

Иргэдийн орон сууцны худалдан авалт буурч байна. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын мэдээнээс харахад тайлант улиралд нийт 2568 шинэ орон сууц борлогдож, гэрчилгээ авсан нь өмнөх улирлаас 26.9 хувиар, өмнөх оны мөн үеэс 31.7 хувиар буурсан дүнтэй байна. Мөн 8 хувийн ипотекийн зээлийн санхүүжилтээр тайлант улиралд нийт 94.5 тэрбум төгрөгийн зээлийг 1281 зээлдэгчид олгоод байна.

Шинээр ашиглалтанд орох орон сууцны тоо буурсан боловч орон сууц худалдан авах эрэлтээс харьцангуй өндөр хэвээр байна. "Тэнхлэг зууч" компаний тооцооллоор 2017 оны 1 дүгээр улиралд нийт 6171 орчим орон сууц шинээр ашиглалтанд орох төлөвтэй байна.

Зураг II.5.4.1

Түрээсийн үнэ болон орон сууцны үнэ уналттай байна.

Эх сурвалж: ҮСГ, судлаачийн тооцоолол

Зураг II.5.4.2

Орон сууцны эрэлт сүүлийн улирлуудад бага байна.

Эх сурвалж: ҮСГ, судлаачийн тооцоолол

Зураг II.5.4.3

Орон сууцны барилгын өртгийн индекс өсөөд байна.

Эх сурвалж: ҮСГ, ЭХЭБГ

Хөрөнгийн захын үзүүлэлтүүд 2016 оны турш хэлбэлзэл өндөртэй байв. Тайлант улиралд ТОП-20 индексийн дундаж үзүүлэлт 7 дугаар сараас эхлэн буурч байсан бол 11 сараас эхлэн өсөх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, ТОП-20 индексийн дундаж үзүүлэлт 2016 оны 4 дүгээр улиралд 11227.2 нэгжид хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 11.7 хувиар, өмнөх улирлаас 8.2 хувиар буурлаа. Харин зах зээлийн үнэлгээ тайлант улиралд 1.39 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 8.7 хувиар өссөн бол, өмнөх улирлаас 2.9 хувиар буурсан байна. (Зураг II.5.4.4).

Тайлант улиралд нийт 3.3 тэрбум төгрөгний хувьцааны арилжаа явагдсан бөгөөд өмнөх оноос буурсан дүнтэй байгаа нь хувьцааны зах зээлийн идэвхжил багассан болохыг харуулж байна. Тайлант улиралд явагдсан хувьцааны арилжааг тодруулбал, “Монгол шуудан” ХК, “Мерекс” ХК, “АПУ” ХК, “Таван Толгой” ХК, "Стандарт проперти групп" ХК гэх таван компаниудийн хувьцаа нийт арилжааны 69.1 хувийг бүрдүүлж байна.

Зураг II.5.4.4

Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ болон ТОП-20 индекс хэлбэлзэл ихтэй байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн биржс

II.6 Төлбөрийн тэнцэл

2016 оны 4 дүгээр улирлын байдлаар урсгал данс 6.7 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 245 сая ам.долларын ашигтай гарч, улмаар нийт тэнцэл 213.9 сая ам.долларын ашигтай гарсан байна[28] (Зураг II.6).

Зураг II.6

Төлбөрийн тэнцэл

Эх сурвалж: Монголбанк

II.6.1 Урсгал данс

Монгол Улсын экспортын 89 орчим хувийг бүрдүүлдэг уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлтийн нөлөөгөөр экспорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 50 хувиар өсч барааны тэнцэл 10 улирлын турш ашигтай гарч байна. Энэ нь урсгал дансны алдагдлыг бууруулах чиглэлд нөлөөлсөн бол Монгол Улсын иргэд, аж, ахуйн нэгж байгууллагуудын гадаад улсаас авсан үйлчилгээний төлбөр өндөр хэвээр байгаа нь урсгал дансны алдагдал өсөхөд нөлөөлсөөр байна (Зураг II.6.1.1).

Зураг II.6.1.1

Урсгал тэнцэл

Эх сурвалж: Монголбанк

Үйлчилгээний гадаад худалдааны хувьд импортын бууралтаас үүдэн тээврийн үйлчилгээний зардал буурч байгаа ч гадаад улсаас авч буй мэргэжлийн үйлчилгээ тогтмол нэмэгдэж байгаа нь алдагдал өсөхөд нөлөөлж байна. Тухайлбал 2016 оны 4 дүгээр улиралд бусад үйлчилгээ буюу уул уурхайн томоохон компаниудын гадаадаас авсан бизнесийн зөвлөх болон барилга, санхүү, архитектур, инженер, техникийн үйлчилгээний зардал нэмэгдсэнээр үйлчилгээний дансны алдагдал өмнөх жилийн мөн үеэс 119.6 сая ам.доллараар өсөв (Зураг II.6.1.2).

Зураг II.6.1.2

Үйлчилгээний гадаад худалдаа

Эх сурвалж: Монголбанк

[28] Тайлант хугацааны статистикийн алдаа ба орхигдуулга -24.4 сая ам.доллартай тэнцүү байв.

Монгол Улсын гадаад өрийн үлдэгдэл нэмэгдэж байгаагаас тэдгээрт төлөх хүү, ногдол ашгийн төлбөр нэмэгдэж, орлогын дансны алдагдал өсөхөд нөлөөлж байна.

Урсгал дансны алдагдал буурч, харин орлогын дансны алдагдал өмнөх жилүүдийн түвшинд байснаар урсгал тэнцлийн алдагдалд эзлэх хувь нь нэмэгдэж байна. Тухайлбал 2013 болон 2014 онд орлогын дансны алдагдал урсгал тэнцлийн алдагдлын харгалзан 20%, 50%-ийг бүрдүүлж байсан бол 2015 он болон 2016 онд харгалзан 102%, 185% болж нэмэгдсэн байна (Зураг II.6.1.3).

Зураг II.6.1.3

Орлогын данс

Эх сурвалж: Монголбанк, ГТЕГ

II.6.2 Хөрөнгө, санхүүгийн данс

Гадаад дотоодын нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй холбоотой 2013 оноос эхлэн ГШХО буурснаар санхүүгийн дансны санхүүжилтийн хэмжээ буурсан. Энэхүү бууралтыг өнгөрсөн хугацаанд багцын болон бусад хөрөнгө оруулалтын дансны ашгаар нөхөж, зарим улиралд гадаад валютын улсын нөөцөөр санхүүжүүлсэн байна (Зураг II.6.2.1).

Зураг II.6.2.1

Санхүүгийн данс

Эх сурвалж: Монголбанк

2016 оны 4 дүгээр улиралд төлбөрийн тэнцэл 213.9 сая ам.долларын ашигтай гарснаар гадаад валютын албан нөөц 2016 оны 12 дугаар сарын эцэст 1296 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 хувиар буурлаа. Энэ нь сүүлийн гурван сарын дунджаар тооцсон валютын төлбөртэй барааны импортын 5.3 сарын хэрэгцээг хангах түвшинд байна (Зураг II.6.2.2).

Зураг II.6.2.2

Гадаад валютын албан нөөц

Эх сурвалж: Монголбанк

II.7 Гадаад эдийн засгийн орчин

Өмнөх улиралтай харьцуулахад 2016 оны IV улиралд БНХАУ, Евро бүс, АНУ, Оросын эдийн засгийн өсөлт нэмэгдлээ. БНХАУ-ын хэрэглээ өсч, үл хөдлөх хөрөнгийн зах зээл сэргэж эдийн засгийг дэмжсэн ч гадаад эрэлт сул байгаагаас экспорт, үл хөдлөх хөрөнгийн салбар дахь хөрөнгө оруулалтын өсөлт буурсан, хувийн секторын өрийн хэмжээ ихэссэн нь эдийн засгийн өсөлт саарах гол хүчин зүйл болж байна. Евро бүсийн дотоод эрэлт газрын тосны хямд үнэ, мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогын нөлөөгөөр өсч, хөдөлмөрийн зах сэргэж эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Харин хөдөлмөрийн захын төлөв сайжирч, хэрэглээ өссөн нь АНУ-ын эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэв. Оросын эдийн засгийн хувьд уул уурхай, хөдөө аж ахуйн салбар идэвхжиж, сэргэх төлөв ажиглагдаж байна.

БНХАУ-ын барилгын салбар эрчимжиж, зэсийн импорт нэмэгдэж эхэлснээс эрэлт нь ихэсч зэсийн үнэ өсөв. Харин 2016 оны 4 дүгээр улиралд дунджаар 1218 ам.долларт байсан нэг унц алтны үнэ Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүгээ 12 дугаар сард 0.25 нэгж хувиар нэмэгдүүлсний дараа 1 дүгээр сард 1193 ам.долларт хүрч, буурав. БНХАУ нүүрсний олборлолтоо танаж эхэлснээс импорт өсч, 2016 оны сүүлээр нүүрсний үнэ өслөө.

II.7.1 Худалдааны гол түнш орнуудын эдийн засгийн байдал

БНХАУ-ын эдийн засаг 2016 оны IV улиралд 6.8 хувиар өсч 2015 оны IV улирлаас хойших хамгийн өндөр түвшинд хүрлээ. БНХАУ-ын Засгийн газрын төсвийн зөөлөн бодлого эрчимтэй хэрэгжиж, хэрэглээ өсч эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүллээ. Хэрэглээ нийт ДНБ-ний 64.6 хувийг эзэлж өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өссөн байна. Түүнчлэн үл хөдлөх хөрөнгийн зах зээл алгуур сэргэж, нийт хөрөнгө оруулалт 2016 онд 6.9 хувиар өссөн нь эдийн засгийн өсөлтөд дэмжлэг боллоо. Үйлчилгээний салбар 2016 онд 7.8 хувиар, үйлдвэрлэл ба барилгын салбар 6.1 хувиар, жижиглэнгийн худалдаа 10.4 хувиар тус тус өссөн байна.

Их Британи Европын холбооноос гарах, дэлхийн улс төр, нийгмийн тогтворгүй байдал зэргээс шалтгаалан БНХАУ-ын гадаад эрэлт саарч, юаны ханш суларсан. БНХАУ-ын экспорт өмнөх улирлаас 2 хувиар буурсан бол импорт 0.6 хувиар өссөн байна.

БНХАУ-ын эдийн засагт тулгамдаж буй асуудал бол өрийн хэмжээ хурдацтай нэмэгдэж байгаа явдал юм. Хувийн секторын өр эдийн засгийн байдалд сөргөөр нөлөөлж байгаагаас БНХАУ-ын шинжээчид 2017 оны эдийн засгийн өсөлтийг 6.7-7 хувьд байхаар тооцож байснаа бууруулж 6.5 хувьд хүргэлээ.

Зураг II.7.1.1

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт, хувиар /өмнөх оны мөн үеэс/

Эх сурвалж: Блумберг, Рубини

ОХУ-ын эдийн засаг 2016 оны II улиралд 0.4 хувиар буурсан бол IV улиралд уул уурхайн салбар сэргэж, аж үйлдвэр, хөдөө аж ахуй эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлж, эдийн засгийн агшилт 0.2 хувь болж буурчээ. Тухайлбал, уул уурхайн олборлолт 2.2 хувиар, хөдөө аж ахуй 3.2 хувиар тус тус өссөн байна. Харин үйлдвэрлэл 1.2 хувиар, бөөний болон жижиглэнгийн худалдаа 3 хувиар, барилгын салбар 2.9 хувиар тус тус буурсан нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.

Инфляци 2016 оны эхнээс үргэлжлэн буурч, 12 дугаар сард 5.4 хувьд хүрсэн тул 2 дугаар сард Оросын төв банкны Мөнгөний бодлогын зөвлөл бодлогын хүүг 10 хувьд хэвээр үлдээв. Инфляци 2017 оны сүүл хүртэл үргэлжлэн буурч Төв банкны зорилтот түвшинд буюу 4 хувьд хадгалагдах төлөвтэй байна.

Зураг II.7.1.2

ОХУ-ын эдийн засгийн өсөлт, хувиар /өмнөх оны мөн үеэс/

Эх сурвалж: Блумберг, Рубини

АНУ-ын эдийн засаг 2016 оны IV улиралд хүлээлтээс доогуур буюу 1.9 хувиар өслөө. Хэрэглээ өссөн ч бизнесийн болон засгийн газрын хөрөнгө оруулалт буурсан нь өсөлтөд сөргөөр нөлөөллөө. Ажилгүйдлийн түвшин 2016 оны 12 дугаар сард 4.7 хувь байсан бол 2017 оны 1 дүгээр сард 4.8 хувьтай гарсан. Ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх сартай харьцуулахад 0.2 хувиар өсч 1 дүгээр сарын байдлаар 62.9 хувьд хүрсэн нь дундаж цалин нэмэгдэж, хувийн хэрэглээ 3 хувиар өсөхөд нөлөөлсөн гэж үзэж байна. Экспорт IV улиралд 4 хувиар буурсан бол импорт 8.5 хувиар өсч, худалдааны нөхцөл -1.7 хувьд хүрэв.

АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн дараагаар Холбооны Нөөцийн Банк 12 дугаар сарын 14-ны өдөр бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар нэмэгдүүлсэн. Дэлхийн санхүүгийн зах зээл тогтворжиж, АНУ-ын ажилгүйдлийн түвшин буурч, инфляци өсч, иргэдийн бодит орлого нэмэгдэж байгаа нь Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүгээ нэмэх шалтгаан болсон гэж шинжээчид үзэж байна. Түүнчлэн Холбооны Нөөцийн Банкны Ерөнхийлөгч Жанет Еллен 2017 оны 2 дугаар сард Чикаго хотод болсон хурал дээр ажил эрхлэлт болон инфляци хүлээгдэж буй түвшинд хадгалагдсаар байвал 3 дугаар сард бодлогын хүүгээ дахин нэмнэ гэж мэдэгдсэн.

Зураг II.7.1.3

АНУ-ын эдийн засгийн өсөлт, хувиар /өмнөх оны мөн үеэс/

Эх сурвалж: Блумберг, Рубини

Евро бүсийн эдийн засаг 2016 оны II, II улиралд 1.6 хувиар өссөн бол IV улиралд 1.8 хувиар өслөө. Евро бүсийн дотоод эрэлт газрын тосны хямд үнэ, мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогын нөлөөгөөр өсч, хөдөлмөрийн зах сэргэж эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Түүнчлэн ажилгүйдлийн түвшин 2017 оны 1 дүгээр сарын байдлаар 9.6 хувь болж буурч, жижиглэнгийн худалдаа өсч эдийн засгийн өсөлтийг дэмжиж байна. Харин инфляци 2017 оны 1 дүгээр сард 1.8 хувьд хүрсэн бол 2 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 2 хувиар өссөн үзүүлэлттэй буюу 2013 оны 1 дүгээр сараас хойших хамгийн өндөр түвшинд хүрчээ. Франц, Бельги, Латви, Герман зэрэг улс орнуудын эдийн засаг IV улиралд эрчимтэй өсч бүсийн өсөлтөд дэмжлэг болсон ч Грекийн өрийн хямрал, цагаачдын асуудал, Их Британи Европын Холбооноос гарахтай холбоотой улс төрийн тодорхой бус байдал хэвээр байгаа нь бүсийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна. 2017 оны 2 дугаар сард аж үйлдвэрийн салбарын идэвхжлийг илтгэх PMI индекс 55.4-д хүрч өссөн үзүүлэлттэй байна. Ийнхүү Евро бүсийн аж үйлдвэрийн салбарын идэвхжил сайжирч, үйлдвэрлэлийн хэмжээ, ажлын байр нэмэгдэхээр байна.

Зураг II.7.1.4

Евро бүсийн эдийн засгийн өсөлт, хувиар /өмнөх оны мөн үеэс/

Эх сурвалж: Блумберг.

II.6.2 Монгол улсын экспортын гол нэрийн барааны дэлхийн зах зээл дээрх үнэ

Зэс: Зэсийн үнэ 2016 оны IV улирлаас эхлэн огцом өсч, 1 дүгээр сард 5743 ам.долларт хүрлээ. БНХАУ-ын барилгын салбар эрчимжиж, зэсийн импорт нэмэгдэж эхэлснээс эрэлт, улмаар үнэ ийнхүү өслөө. Өнгөрсөн онд болсон АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн зэсийн үнэ өсөхөд мөн нөлөөлжээ. Трампын ялалтаас хойш зэсийн үнэ тогтвортой өсч 6000 ам.долларын түвшинд хүрээд 2 дугаар сарын сүүлийн байдлаар зэсийн нийлүүлэлт их, эрэлт сул байгаагаас зэсийн үнэ буурах хандлага зах зээл дээр давамгайлж байна.

Алт: 2016 оны II улиралд дунджаар 1336 ам.доллар, IV улиралд 1218 хүрээд байсан нэг унц алтны үнэ 1 дүгээр сард 1193 ам.долларт хүрч буурлаа. 2016 оны IV улирлаас дэлхийн үнэт цаасны зах зээл сэргэж, Холбооны Нөөцийн Банк 12 дугаар сард бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар нэмэгдүүлснээр ам.долларын ханш чангарч алтны үнэ буурлаа. Гэсэн хэдий ч 2 дугаар сарын байдлаар алтны үнэ эрчимтэй сэргэж байна. Учир нь ам.долларын ханш эргэн суларч, Трампын цаашдын худалдааны болон татварын бодлогын тодорхой бус байдал нь хөрөнгө оруулагчид алтны зах зээл рүү эргээд хөрөнгийн урсгалаа чиглүүлэхэд хүргэж алтны ханшид дэмжлэг болохоор байна.

Хүрэн нүүрс: 2016 оны сүүлийн хагаст дунджаар 61$, 11, 12-р саруудад дунджаар 74$ байсан нэг тонн хүрэн нүүрсний үнэ 2017 оны 1 дүгээр сард 84 ам.долларт хүрч өсчээ. Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор БНХАУ улс нүүрс олборлолтоо танаж эхэлснээс хүрэн нүүрсний импорт өсч, үнэ өссөн. Ийнхүү 2017 оны 1 дүгээр сард нүүрсний үнэ дээд цэгтээ хүрээд байсан хэдий ч бага багаар буурсаар байна. Өвлийн өндөр эрэлттэй холбогдуулаад БНХАУ-ын ЗГ нүүрсний үйлдвэрлэлийг хязгаарлах бодлогоо зөөлөрснөөс үнэ 11 дүгээр сараас хойш 2 дугаар сарын байдлаар аль хэдийнээ 14 хувиар бууруаад байна.

Коксжих нүүрс: Австралийн Японтой хийсэн сайн чанарын коксжих нүүрсний гэрээний жишиг үнэ 2016 оны 12 дугаар сард 200 ам.доллар байсан бол 2017 оны 1 дүгээр сард 285 ам.долларт хүрчээ. Хятад улс дотоод дахь олборлолтоо бууруулсан нь коксжих нүүрсний импорт нэмэгдэхэд нөлөөлж, үнийг өсгөв. Гэвч сайн чанарын коксжих нүүрсний жишиг үнэ 2 дугаар сарын байдлаар огцом буурсан дүр зураг ажиглагдаж байна. Өнгөрсөн оны сүүлээр үнэ 300 ам. долларт хүрээд байсан ч үүнээс хойш ийнхүү үргэлжлэн буурсаар байна. 2 дугаар сарын сүүлийн байдлаар сайн чанарын коксжих нүүрсний үнэ 150 ам.доллар болтлоо буурлаа. Ийнхүү АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн гарснаас хойших хугацаанд сайн чанарын коксжих нүүрс хамгийн их уналттай түүхий эдүүдийн жагсаалтыг тэргүүлж байна.

Түүхий нефть: : Брент маркийн газрын тосны үнэ 2017 оны 1 дүгээр сард 55 ам.доллар болж өслөө. ОПЕК-ийн үйлдвэрлэлээ танах шийдвэрийн дараа нийлүүлэлтийн илүүдэлд ороод байсан газрын тосны зах зээлд үнэ ханш эргээд сэргэх чиглэл ажиглагдаж эхэлснээр 2016 оны сүүлээс үнэ өсч эхэлсэн. Он гарснаас хойш ОПЕК болон ОПЕК-ийн бус орнуудын гол нийлүүлэгчид үйлдвэрлэлээ бууруулах шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих арга замаа тодорхойлж, нэгдсэн ойлголтод хүрснээр үйлдвэрлэлт цаашдаа бодитой буурах хүлээлт бий болж, үнэ өсөх хандлага улам ихээр ажиглагдсан. Гэвч АНУ-ын олборлогчид эсрэгээрээ олборлолтоо тасралтгүй нэмэгдүүлсээр байгаа нь зах зээл дээр үнэ буурах нөхцлийг бүрдүүлж байна.

МОНГОЛБАНК